
НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГЫН
ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ КОНВЕНЦИЙН

ХЯЛБАРЧИЛСАН

ГАРЫН АВЛАГА

НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГЫН
ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ КОНВЕНЦИЙН

ХЯЛБАРЧИЛСАН

ГАРЫН АВЛАГА

**Цөлжилттэй тэмцэх конвенцийн хялбарчилсан
гарын авлага, Яагаад хэрэгтэй вэ? Юу нь чухал вэ?
Юугаараар өөр вэ?**

**Цөлжилттэй тэмцэх конвенцийн
нарийн бичгийн газраас эрхлэн гаргав.**

**Хянан тохиолдуулсан БОАЖЯамны
Гадаад харилцааны хэлтэс**



Монгол улсын
Байгаль орчин, аялал
жуулчлалын яам

Цөлжилттэй тэмцэх
конвенцийн Монгол
дахь зохицуулагч:

Монголын улсын
Цөлжилттэй тэмцэх
үндэсний хороо



Secretariat of the United Nations
Convention to Combat
Desertification
(UNCCD)

Langer Eugen
Hermann-Ehlers-Str. 10
D-53113 Bonn

Germany

Tel. +49 228 8152800

Fax. +49 228 8152899

Email: secretariat@unccd.int

Web home page: www.unccd.int

Written by Geoffrey Lean

First published June 1995

Last updated March 2008

No use of this publication may be made for resale
Or any other commercial purposes

All rights reserved

ISBN 92-95043-11-1

Copyright 1995

Cover photo: Arthur Gloor/PNUE/SELECT
illustration: Jacques Mercoiret

Агуулга

Хэсэг 1: Асуудалууд

1. Бид өөрсдийн зогсох талбараа алдсаар байна
2. Цөлжилт гэж юу вэ?
3. Парис хүрэх зам
4. Зарчмын асуудал
5. Тусламж дэмжлэгээс хамтын ажиллагаа руу
6. Дороос дээш үйлчлэх хандлага
7. Хамдтаа ажил хэрэг болгоё
8. Хүрээгээр өргөжүүлэх нь
9. Нөхцөл бүрдүүлэх

Хэсэг 2: Хэрэгжүүлэлт

10. Үйл ажиллагааны хөтөлбөрүүд
11. Чадавхи бүрдүүлэх
12. Шинжлэх ухаан, технологи
13. Санхүүжилт
14. Байгууллага, зарчим
15. Африк
16. Бусад бүс нутаг
17. Цаашид арга хэмжээ



Долоо дахь хэвлэлд зориулсан өмнөтгөл

Рио-гийн дээд хэмжээний уулзалтын нэг чухал үр дүн болсон НУБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц бол газрын доройтлыг олон нийтийн анхаарлын төвд авчирсан онцгой хэрэгсэл юм. Газрын доройтол бүхий нутагт дэлхийн хамгийн эмзэг экосистемийн зарим хэсэг нь байж, мөн тэнд гамшигт өртөх эрсдэл бүхий хамгийн эмзэг хүмүүсийн зарим нь амьдарч байна. Байгаль орчны асуудалтай холбогдуулан байгуулсан олон улсын гэрээ хэлэлцээрүүд дотроос хамгийн олон буюу 193 талын гишүүнчлэлтэй конвенц юм. Тус Конвенцийг Серби улс хамгийн сүүлд 2008 оны 3 дугаар сарын 17-нд соёрхон баталсан байна.

Өнөөдөр НУБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц анх хүчин төгөлдөр болж байсан 1996 оны үеийн нөхцөл байдлаас харьцангуй ихээр өөрчлөгдсөн орчинд байна. Рио-гийн дээд хэмжээний уулзалт болж байсан үеэс ихэвчлэн эхтэйгээр хөгжлийн талаархи зарчим нилээдгүй өөрчлөгдсөн бөгөөд үүнд Мянганы хөгжлийн зорилтыг баталсан явдал ихээхэн нөлөөлсөн юм. Африк тив болон нэн буурай хөгжилтэй улс орнуудын асуудал, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах үүнд дасан зохицоход илүү их анхаарал хандуулах болсон, хөдөө аж ахуйд худалдааг либеральчлах буюу чөлөөлөх зэрэг асуудлууд ядуурал ба байгаль орчны доройтлын нөлөөллийг өөрөөр харах учиртай болголоо.

Үүнээс гадна Мянганы экосистемийн үнэлгээг хийснээр шинжлэх ухааны шинэ орчин бий болсон бөгөөд энэхүү үнэлгээ нь дэлхийн хуурай гандуу газар нутгийн доройтол, түүнээс хүний ба экосистемийн сайн сайхан байдалд үзүүлэх нөлөөлөлтэй холбоотой биофизикийн ба нийгэм-эдийн засгийн чиг хандлагыг ойлгоход ихээхэн дэмжлэг болсон юм. Конвенцийн санхүүгийн механизм болсон Даян дэлхийн байгаль орчны сан байгуулагдсан явдал нь санхүүгийн орчинг ч тэр сүүлийн арван жилд ихээхэн өөрчилсөн юм. Хөгжлийн албан ёсны тусламжийн урсгал арван жил орчмын хугацаанд дороо дэхвэцсэн он жилүүдийн дараа, хөдөөгийн хөгжил, хөдөө аж ахуйд шаардлагатай хөрөнгө санхүү байнга буурч байсны дараа дахиад урсгаж эхэллээ.

Эргэн тойронд болж байгаа иймэрхүү нөхцөл байдлын дунд Мадрид-д хуралдсан Конвенцийн Талуудын Бага хурлын 8 дугаар хуралдаанаар Арван жилийн стратеги төлөвлөгөө ба Конвенцийг хэрэгжүүлэх бодлогын баримт бичиг (Стратеги - Хэтийн чиглэл) —үүдийг нэгэн дуугаар баталсан билээ. Стратеги буюу хэтийн чиглэлийн тухайд уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн нөхцөл байдалд цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааг газрын доройтол ба ган гачигтай холбоотойгоор хамтатган авч үзэж ингэснээрээ бүх түвшний тухайд ашигтай байх, хоол хүнс цэвэр усны хангамжийн асуудлыг шийдвэрлэх, тогтвортой амьжиргаа, биологийн олон янз байдлыг хамгаалах асуудалд хувь нэмрээ оруулахын ач холбогдолтой болохыг онцлон үзэж байна.

Цөлжилтийн асуудлыг дэлхийн хэмжээний асуудал гэж хүлээн зөвшөөрөх шаардлагатай. Бид, та бүхэнтэй хамтарч НУБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенцийг газар, түүний экосистемд нөлөөлж байгаа байгаль орчны асуудалд зохион байгуулалттайгаар дэлхийн хэмжээнд хариу барих шинэчлэгдсэн үүрэг бүхий Конвенц болгох шинэ арван жилийн өмнө ирээд байна.

A handwritten signature in blue ink, located at the bottom center of the page. The signature is stylized and appears to read "Lyuk Gnacadja".

Льюк Гнакаджа
НУБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенцийн Гүйцэтгэх захирал

1 Бид өөрсдийн зогсох талбараа алдсаар байна

Манай гаригийг Дэлхий буюу англиар хөрс гэж нэрлэдэг нь санамсаргүй хэрэг биш. Газар дээрх бүхий л амьдрал дэлхийг бүрхэж байдаг ихээхэн эмзэг, хөрсний нимгэхэн үе давхаргаас хамааралтай байдаг. Үүнгүйгээр, амьд биетүүд далайн уснаас хэзээ ч гарч ирэхгүй байхсан: ургамал байхгүй, үр тариа байхгүй, ойн амьтан байхгүй цаашлаад хүн байхгүй байхсан.

Энэхүү эрдэнэс мэт үнэтэй, манай гаригийн мах цус болсон хучлага маань хэтэрхий удаан хугацаанд бүрэлдэн бий болдог бөгөөд харин түүнийг устгахад маш хугацаа шаардлагатай. Ганцхан ямхын хэмжээтэй хөрс бүрэлдэн бий болохын тулд хэд хэдэн зуун жил шаардагдах бол, буруу арчлаад байх тохиолдолд хэдхэн улирлын хугацаанд салхиар үлээгдэн эсвэл усаар угаагдан алга болж болно. Яг ийм байдлаар манай дэлхий буюу англиар хэлбэл хөрс хэмээх нэрийг нь зээлж авсан гариг маань нэн хурдтайгаар сүйрч байна.

Дэлхийн нийт хүн амын гуравны нэг нь болох 2 тэрбум орчим хүний орон гэр болсон хуурай гандуу газар нутгаас өөр хаана ч, хямрал ийм хүчтэйгээр мэдрэгдэхгүй. Цөлжилт улам бүр нэрмээс болж байгаа чухам энэ газар нутагт л хөрс хэт эмзэг, ургамлын нөмрөг дорой, уур амьсгалын нөхцөл байдал ширүүн байна. Цөлжилтөд өртөмтгий хуурай гандуу газар нутаг дэлхийн хуурай газрын 45 хувийг эзлэх бөгөөд үүний 10-20 хувь нь ямар нэгэн байдлаар аль хэдийнээ доройтолд оржээ. Үүний улмаас газрын доройтлын нөлөөнд 250 сая илүү хүн шууд өртсөн байна. Газрын доройтох үйл явц Африк тивийн газар нутгийнх нь 46 хувийг хамарсан учраас энэ тивийн гамшигт өртөх аюул онцгой байдалтай байна. Ази тивийн тухайд, цөлжилт ба ган гачгийн нөлөөнд өртсөн хүмүүсийнх нь тоогоор авч үзвэл гамшигт хамгийн ихээр өртсөн байна.

Газрын доройтох үйл явц хаана ч тохиолдож болох боловч хуурай гандуу газар нутагт л үүнийг “цөлжилт” гэж тодорхойлж байгаа юм. Бодитоор авч үзвэл цөлжилт гэдэг нь буруу ойлголтыг бий болгож байгаа нэр томъёо юм. Цөлжилт хамрах хүрээгээ тэлж байна гэсэн таамгийн хүрээнд авч үзвэл заримынх нь тухайд, элс улам бүр түрэх замаар үржил шимтэй газар нутгийг эзэлж байна. Ерөнхийдөө уур амьсгал ба хур тунадасны хэмжээний өөрчлөлттэй холбоотойгоор цөл газрын хил заримдаа тэлж заримдаа багасаж байдаг нь үнэн боловч энэ нь огт өрдэв юм. Цөлжилт гэдэг нь арьсны өвчинтэй илүү төстэй үзэгдэл билээ. Доройтолд өртсөн хэсэг бусгаг газрууд хамгийн ойрхон байгаа цөлөөс зарим тохиолдолд хэдэн мянган километрийн хол зайтай газар гэнэт бий болох тохиолдол байдаг. Аажмаар нөгөө хэсэг бусгаг газрууд маань тэлэх замаар хоорондоо нийлээд цөл маягийн нөхцөл байдлыг үүсгэдэг.

Цөлжилт ба газрын доройтол нь орчны доройтол, ядуурал, шилжилт хөдөлгөөн, зөрчилт байдал, гамшигт өртсөн улс орнууд болон эрсдэлтэй бүс нутгийн тухайд улс төрийн тогтворгүй байдал бий болох зэрэг урхаг ихтэй битүү тойргийг үүсгэж болно. Өнөөдөр дэлхий дээр гарч байгаа цэргийн үйл ажиллагаа оролцсон хямралын хагас нь хуурай гандуу газар нутагт элбэг тохиолдох байгаль орчны хүчин зүйлээс үүдэлтэй гэж тооцоолсон бөгөөд энэ газар нутгийн хямралд өртөх магадлал уур амьсгалын өөрчлөлт, ган гачиг тохиолдох явдал, цаг агаарын эрс тэрс нөхцөл байдал зэргийн улмаас улам бүр ихсэж байна.

Ган гачгийн улмаас цөлжилт ба газрын доройтол улам бүр эрчимжиж байгаа ба тэднийг шинээр бий болгож байна. Гэхдээ үүнд хүний гүйцэтгэж байгаа дөрвөн үүрэг хамгийн

үндсэн шалтгаан болж байна. Хэт тариалах явдал хөрсийг туйлдуулж байна. Бэлчээрийг хэт ашиглах нь элэгдлээс хөрсийг хамгаалдаг ургамлын нөмрөгийг хуулж хаяж байна. Ойг огтлох нь хөрсийг газартай барьж байдаг модыг устгаж байна. Үүнээс гадна, үр ашиг багатай ашиглаж байгаа услалтын систем тариалангийн талбайг давсжуулж байна. Дэлхий даяар, усалгаатай талбайн 20 орчим хувь (450 км кв.) нь давсжсан бөгөөд үүнээс үүдэн жил бүр 2,500-5,000 км кв. газар нутаг газар тариалангийн үйлдвэрлэлээс хасагдаж байна (НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр UNEP).

НҮБ-ын ган гачиг ба/буюу цөлжилтөд хүчтэй нэрвэгдэж байгаа нэн ялангуяа Африкийн улс орнуудын Цөлжилттэй тэмцэх конвенц (UNCCD) 1992 онд Рио де Жанейро-д болсон Дэлхийн дээд хэмжээний уулзалтаар дэлхийн удирдагчдын хүлээн зөвшөөрч уур амьсгалын өөрчлөлт ба хүний үйл ажиллагааг хамгийн гол буруутан хэмээн нэрлэж байгаа цөлжилтийн тодорхойлолтыг баталсан билээ. “Цөлжилтийн учир шалтгаан нь физик, биологи, улс төр, нийгэм, соёл, эдийн засгийн хүчин зүйлийн харилцан цогц үйлчлэлээс үүдэлтэй” гэж нэмж өгүүлсэн байна. Хүн амын тоо, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдсэнээр газартай харьцах уламжлалт арга туршлага алдагдах бөгөөд энэ нь шинэ ихэвчлэн нэг төрлийн үр тарианы ургамал тариалах арга техник нэвтэрснээр бүр ч хэлмэгдэж байна. Ингэснээр улам их хэмжээний үржил шим сайтай газрыг зохистой хамгаалалтын арга хэмжээнд хамруулалгүйгээр ашиглах болж, ядуу хоосон тариачид, малчид үржил шим тааруухан хамгийн зах хязгаарын нутаг руу шахагдаж байна.

Дээхэн үедээ, хуурай гандуу газар нутагт амьдарч байгаа ард иргэдийг өөрсдөө газар нутгаа хэт ихээр ашиглаж, модоо ихээр тайрч байгаа учраас амьжиргаагаа өөрсдөө сүйтгэж байна хэмээн шүүмжилж байлаа. Гэхдээ тэднийг өөр ямар ч аргагүй болгосон илүү гүнзгий учир шалтгаанууд бий. Тэдний дунд ядуурал хамгийн голлох шалтгаан юм. Ядуурал нэрвэгдсэн иргэд хэдийгээр маргаашийн боломжоо үгүй хийж байгаа боловч зөвхөн өнөөдөр гэр бүлээ тэжээх зорилгоор газраас авч болох бүхий л зүйлийг авахаар тэмүүлж байна.

Хуурай гандуу газар нутгийн ядуус, ирээдүйдээ юу болох тухай, ирээдүйн хувь заяаныхаа тухай хэлэх юмаар тун хомс. Тэднийг өөрийн улс орон нь ч тоож үзэхгүй байх нь элбэг бөгөөд хамгийн зах хязгаарын нутаг руу шахагдсан, газар ашиглах эрх байхгүй, үндэсний болон бүс нутгийн түвшний бодлогод нөлөөлөх зүйлээр ядмаг байх нь элбэг. Тэд бол дэлхий дээр байдаг дуу чимээ багатай ард түмний дундаас, эдийн засаг, улс төр, газарзүйн тухайд алианаар нь ч тэр болгон харагддаггүй энэ утгаараа хамгийн чимээ аниргүй хүмүүс бөгөөд ялангуяа эмэгтэйчүүдийн тухайд авч үзэх юм бол, тэд цөлжилтийн нөлөөнд хамгийн их өртөж байгаа хүмүүс бөгөөд бусдад тэдний үзүүлэх нөлөө маш бага, тэр бүү хэл өөрийн тосгон болон өөрийнхөндөө ч тэр бүр байхгүй байх нь их.


Ер нь бол цөлжилт ба газрын доройтол нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй холбоотойгоор нийгэмд эзэлж байгаа байр суурь, гүйцэтгэж байгаа үүргээс хамаарч тэдэнд өөр өөрөөр нөлөөлдөг байна. Орон нутгийн иргэдэд ойрхон байршилтай байгаа байгалийн ямар нэгэн нөөц баялаг шавхагдаж эхлэхэд, үүнтэй холбоотой бэрхшээлийг даван туулах ямарваа ажиллагаа эмэгтэйчүүдийн мөрөн дээр бууж тэд олон км алхах, тэгэхдээ нилээн тохиолдолд аюултай сөрөг нөхцөл байдлыг даван туулах шаардлагатай болдог. Тэдний хоол хүнс, ус, түлээ түлш цуглуулахтай холбоотой ажлын хэмжээ ихээхэн нэмэгддэг байна. Хөрсний үржил шим буураад ирэхээр үр тарианы ургац, нэмэлт орлого олох эх үүсвэр ч бас дагаад буурдаг. Ингээд тухайн гэр бүл өөрсдийн өдий хүртэл амьдарч ирсэн уламжлалт арга хэлбэрээр амьдрах аргагүй болоод ирэхээр эрчүүд нь нэг бол улирлын чанартай эсвэл бүрмөсөн шилжээд явдаг байна. Энэ асуудал эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг улам дордуулдаг бөгөөд учир нь нэг талаасаа тэдний ажлын ачаалал нэмэгдэж байгаа бол нөгөө талаас хөрсний үржил шим муудсанаас шалтгаалж бүтээгдэхүүний үйлдвэрлэл багассантай холбоотой байдаг байна.

Гэхдээ л цөлжилт гэдэг бол зөвхөн хөгжиж байгаа улс орон эсвэл хэсэг бүлэг хүмүүсийн хувьд тулгараад байгаа асуудал биш юм. Хуурай гандуу газар нутгийнхаа цөлжсөн (хэт эсвэл дунд зэрэг) хэмжээ – 74 хувь - гээр Хойт Америк нь тивүүд дотроо хамгийн эхэнд орно. Европын холбооны улс орнуудаас 13 нь цөлжилтөд нэрвэгдэж байна. Нийтэд нь аваад үзэхээр дэлхий дээр 110 гаруй улс орон эрсдэлд байна. НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн тооцоолсноор цөлжилтийн улмаас жил бүр 42 тэрбум долларын хохирол учирч тэр дундаа Африк тив дангаараа жилд 9 тэрбум доллараа алдаж байна.

Хөгжлийн төлөвлөгөөг боловсруулагчид өмнө нь хуурай гандуу газар нутгийн хүмүүсийн асуудлыг анхаарлын гадна үлдээх нь дэндүү олонтаа тохиолдож байлаа. Гэхдээ л ядуучууд гэдэг бол олон жилийн турш хишиг үр шимийг нь хүртэж ирсэн эмзэг экосистемийнхээ тухай хэнээр ч заалгалтгүй хамгийн сайн мэддэг хүмүүс билээ.

Чухам тэд л цөлжилттэй тэмцэх ажлын түлхүүр болж өгөх учиртай юм.

НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц хамтын оролцооны хүчээр хөгжил дэвшилд хүрэх үзэл санааг илэрхийлж байдаг юм. Цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрийг орон нутгийн түвшнээс санаачилж, жинхэнээсээ орон нутгийн оролцоотой байх ёстой гэж конвенц үздэг. Нэгэнт төлөвлөгөө болгочихсон байгаа санал санаачлагыг хамтаар эзэмших явдал бол түүний тогтвортой байхын үндсэн нөхцөл болж өгдөг. Ингэснээр нэг талаараа цөлжилтийг зогсоох, түүнийг буцааж эргүүлэх бол, нөгөө талаараа зарим ядуу иргэдийн орлого нэмэгдэх, мөн тэдний өөрсдийгөө хүндэтгэх бахархлыг төрүүлж ингэснээр тэднийг газар дээрээ үлдэх байр суурийг нь бэхжүүлэх хоёр талын ач холбогдолтой болох юм. Энэ үзэл баримтлал нь цөлжилтийн олон талтай, бие биентэйгээ барьцалдсан олон янзын хямралтай амжилттай тэмцэх хамгийн тэргүүний, магадгүй цорын ганц боломж ч байж болох юм.



2 Цөлжилт гэж юу вэ?

Цөл хамрах хүрээгээ тэлж байна уу? Хааяа гамшиг болох үед гэнэт гарч ирээд асуудал болоод байдгийг нь эс тооцвол элс аажмаар нүүгээд хүрээгээ тэлээд байгаа юм байхгүй. Удаан хугацаагаар бороо орохгүй байгаа үед цөл тэлээд байгаа юм шиг харагдах боловч бороо хур сайтай үед энэ байдал эргээд засагддаг байна.

Тэгэхлээр, бүх зүйл давгүй гэсэн үг үү? Үгүй шүү. Газар доройтох явц үргэлжилж байна, мөн анхаарал хандуулахаас өөр аргагүйгээр их хурдтай болж байна. Ингэснээр дэлхийн үржил шимтэй газар нутгийн үнэт агуулах маань элэгдэж эмтэрч байна. Иймэрхүү үзэгдэл хуурай гандуу газар нутагт тохиолдоход цөл маягийн нөхцөлийг бий болгодог бөгөөд үүнийг “цөлжилт” гэж нэрлээд байгаа юм. Цөл газар хүрээгээ тэлж байгаа гэхээсээ илүү доройтсон нутгийн зарим газар хүрээгээ тэлж хоорондоо нийлэх байдлаар энэ үйл явц алхам алхмаар ахиж байна.



Энэ чинь тэгээд Бурханы хийж байгаа ажил юм уу эсвэл цаг агаар юм уу? Аль нь биш. Ган гачиг гэдэг бол цөлжилтийн шалтгааны нэг нь л бөгөөд байдлыг улам муудуулж байгаа нь үнэн. Гэхдээ л эцсийн дүндээ энэ бол хүний бий болгож байгаа асуудал юм. Хэтэрхий их ачааллыг газарт үүрүүлсэн нь байдлыг ийм болгож байна.

Энэ нь хөгжиж байгаа улс орны ядуучуудын л асуудал юм уу? Үгүй. Дэлхийн бөмбөрцгийн хамгийн эмзэг нутагт амьдарч байгаа, хамгийн ихээр гадуурхагдсан, хамгийн ядуу 1 тэрбум хүн цөлжилтийн

аюулд хамгийн ихээр нэрвэгдэх магадлал өндөр байна. Гэхдээ өөр хохирогчид бас байна. Хөгжингүй 18 улс орон цөлжилтөөс болж хохирч байна. Хөгжиж байгаа улс орны тухайд хөгжил дэвшлийн хувьд илүү хэмээн харж явдаг хөгжингүй улс орнууд нь цөлжилтийн нөлөөнд шууд бус (хөгжиж байгаа орны хүмүүс доройтсон газар нутаг дээрээ амьдрах аргагүй болоод ирэхээрээ хөгжингүй улс руу ихээр цагаачилж байна) — аар автагдаад эхэлсэн нь хөгжингүй улс орнуудыг ч бүхэлд нь цөлжилтөнд нэрвэгдэж байна гэдгийг харуулж байна. Хаа нэгэн газар ядуурал газар авах нь бусад газрын хөгжил цэцэглэлтийг аюулд оруулдагийн хамгийн тод жишээг цөлжилт харуулж байна.

Тэгвэл, Цөлжилт гэж юу юм бэ, тэгээд? Дээд хэмжээний уулзалтаар 1992 онд дэлхийн удирдагчид хүлээн зөвшөөрч, Конвенцийн баталсан тодорхойлолтоор цөлжилт гэдэг бол “уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагаа зэрэг янз бүрийн хүчин зүйлийн улмаас хуурай, хагас хуурай, хагас чийглэг газар нутагт тохиож байгаа газрын доройтол” юм

З Парис хүрэх зам

Газрын доройтол нь Хятадын тариалангийн талбайгаас Инкийн эзэнт улсын хөгжил цэцэглэлтийн оргил үе хүртэлх соёл иргэншлийн нэгэн адил түүхэн үзэгдэл юм.

Дэлхийн хамгийн эртний бичгийн дурсгал болох Сумерийн баатарлаг дуулал-д хүн Месопотамийн ойг хэрхэн огтолж ялаа шумуулаас салж байгаа тухай өгүүлсэн байдаг. Эртний Сумерянчууд хавсарга нөлөөг анхаарч үзэлгүйгээр ойг огтлох үйл ажиллагаагаа гол болгосон байна. Тэдний МЭӨ 2000 оны үеийн бичгийн дурсгалд дурьдсанаар нэн урхагтай үр дагавар бүхий цөлжилтийн талаар тодорхойлсон байна. Сумерянчуудын агуу их хот улс нэгэн үе 50,000 хүнтэй байсан Урур өнөөдрийн Хойд Америкийн хурааж байгаа үр тарианы хэмжээтэй тэнцүү хэмжээний тариа хурааж байсан бол түүнээс өнөөдөр зөвхөн элсэнд хучигдсан хэдэн овгор шороо л үлдсэнийг харж болно.

МЭ 4 дүгээр зуунд Аттикийн Плато бичихдээ: “газар нутаг маань өмнө нь ямар байсантай нь харьцуулах юм бол өвчинд баригдсан хүн турж эцээд, араг яс шиг л болсонтой адилхан болсон байна” гэж өгүүлж байжээ. Ромын эзэнт улсын үр тариаг нийлүүлж байсан, нэгэн цагт 600 хот нэгэн зэрэг цэцэглэн хөгжиж байсан хойд Африк өнөөдөр цөл болж хувирсан байна. Кристофер Колумбус Гайтийн толгодоор шуугин найгаж байгаа ойг хараад “амьдралдаа иймэрхүү гайхамшигийг хараагүй” тухайгаа өгүүлж байсан бөгөөд одоо тэр газар нь элэгдэлд идэгдсэн нүцгэн газар болсон байхыг харж болно.

Яах ч аргагүй эвдрэл сүйрлийн түүх болж байна. Хуурай гандуу газар нутгийн ард иргэд хөрсний үржил шимийг хэтрүүлэн ашиглалгүйгээр харин ч түүнийгээ аргадах, арчлах, үржил шимийг нь хүртэх өөрийн гэсэн технологитой болсон байжээ. Тухайлбал, Алжирийн тал нутгийн ард иргэд нүүдэлчдийн нэгэн адилаар улирлын өөрчлөлт, уур амьсгалын хувьсал өөрчлөлтөд дасан зохицож 20 сая га газар нутагтаа нүүдэллэж ирсэн бөгөөд энэ нь газарт учруулах дарамтыг аль болохоор багасгах мөн хойд зүгт нь байгаа суурин тариачид, өмнө талд нь байгаа баян бүрдийн иргэдтэй бараа солилцох зэрэг нэмэлт боломжийг олгож байжээ.

Цөлжилтэй тэмцэх анхны оролдлого Сахелийн их ган ба 200,000 хүний амийг авч одсон, сая сая толгой малын гарз хохирол дагуулсан 1968-1974 оны их өлсгөлөнгийн дараа эхэлсэн байна. НҮБ-ын Судан-Сахелийн алба 1973 онд байгуулагдсан бөгөөд анхны зорилт нь Баруун Африкт орших дээрх гамшигт нэрвэгдсэн есөн улс оронд туслах байсан боловч үүний үйл ажиллагаа тэр цагаас хойш ихээхэн өргөжсөн байна. Тусламжийн ажиллагааг Сахараас урагш экватороос хойш орших 22 улс оронд хэрэгжүүлэхээр болж өргөжүүлсэн байна. Барагцаалбал тэр үед Африкт дэд бүс нутгийн байгууллагууд бий болж эхэлсэн байна. Үүнтэй нэгэн адилаар, Хөдөө аж ахуйн хөгжлийн Олон улсын сан 1985 онд бас нэгэн гамшигт ган болсны дараахан Ган гачиг ба цөлжилтийн нөлөөнд нэрвэгдэж байгаа Саб Сахарын улс орнуудад зориулсан Тусгай хөтөлбөрөө боловсруулсан байна: үүгээр дамжуулж 400 сая долларыг шууд босгосон бөгөөд, үүнийг бусад байгууллагуудын зэрэгцүүлж гаргах 350 сая доллартай нийлүүлэн 25 улсад нийт 45 төслийг санхүүжүүлэхэд зарцуулсан байна. НҮБ цөлжилтийн талаархи энэхүү асуудлыг Найроби-д 1977 онд болсон НҮБ-ын Цөлжилтийн асуудлаархи Бага хурлаар анх дэлхий дахины анхааралд гаргаж ирсэн бөгөөд үүгээр цөлжилтийг дэлхий дахиныг хамарсан эдийн засаг, нийгэм, байгаль орчны асуудал хэмээсэн юм. Үүгээр цөлжилтийн нөлөөнд өртөж байгаа улс орнуудад тухайн асуудалтай тэмцэхэд шаардлагатай төлөвлөгөө боловсруулах, олон улсын хамтын нийгэмлэгийг энэ асуудалд анхаарлаа хандуулах, тэдний үзүүлэх туслалцааг уялдуулан зохицуулахад нь дэмжлэг үзүүлэх зэрэг бусад олон зорилттой баримтлах чиглэл, гарын авлага, зөвлөмж бүхий Цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан байна. Зарчмын хувьд, Үйл ажиллагааны төлөвлөгөө бүх л зүйлийг хамруулсан байсан бөгөөд, үүнийг 1990 онд хийсэн хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт харуулсан боловч амьдрал дээр үүний хэрэгжилт хүлээж байсан үр дүнгийнхээ хаана нь ч хүрээгүй байна.

Эхний үед, цөлжилтөд нэрвэгдсэн улс орнууд ч тэр, олон улсын тусламж дэмжлэг ч тэр

асуудалд анхаарал хандуулж ач холбогдол өгөөгүй байна.

1980 онд хийсэн судалгаагаар хэрвээ энэхүү төлөвлөгөөг бүрэн дүүрэн хэрэгжүүлнэ гэвэл жил бүр 4.5 тэрбум доллар зарцуулах шаардлагатай байгааг харуулсан байна: үүнээс 2.4 тэрбум нь гадаадын тусламж дэмжлэгээс ихээхэн хамааралтай байдаг улс орнуудад шаардлагатай. Гэлээ ч шаардагдах хөрөнгийн зөвхөн дөрөвний нэг нь буюу 0.6 тэрбум долларийг л олж зарцуулж чадсан байна. Үүнээс гадна, цөлжилтөд нэрвэгдэж байгаа улс орнуудаас дөнгөж 20 нь л цөлжилттэй тэмцэх Үндэсний хөтөлбөрөө 1991 он буюу Үйл ажиллагааны төлөвлөгөөг зөвшөөрч баталснаас хойш 14 жилийн дараа боловсруулсан байсан байна.

Цөлжилттэй тэмцэхтэй холбоотой үйл ажиллагааг тодорхой улс орон ба хандивлагчид авч хэрэгжүүлж байгаа тохиолдолд энэхүү хүчин чармайлт нь хамтын ажиллагаа сул байгаагаас шалтгаалаад сулрах байдал бас ажиглагдаж байлаа. Тусламж үзүүлж байгаа улс орон, байгууллага хүлээн авагч талаа өөрсдийн үзүүлэх тусламжийн нөхцөл болгон шинэ төлөвлөгөө (өөр нэгэн хандивлагчийн шаардлагаар боловсруулсан бас нэгэн ижил төстэй төлөвлөгөөтэй огт хамаагүй) боловсруулсан байх ёстой гэж тулгах явдал байнга ажиглагдаж байгаа бөгөөд тэдгээр төлөвлөгөөг хэрэгжүүлэх эсэхэд анхаарал тавихгүй байна. Энэ шалтгаанаар улс орнууд хэсэг бусад хэрэгжсэн төлөвлөгөөтэй л үлдэж байна. Үүнээс ч чухал бас нэг асуудал байгаа нь цөлжилтийн нийгмийн урхагийн асуудалд маш бага анхаарал хандуулж байгаагаас цөлжилтөд өртөж байгаа хүмүүс зохих зөвлөмж авахгүй үүнээсээ шалтгаалаад асуудлын бүр гадна нь үлдэх явдал ажиглагдаж байна. Асуудал улам л дордож байна.

Хэдийгээр Конвенцийн өмнөтгөлд “өнгөрсөн хугацаанд улс гүрнүүд, олон улсын байгууллагуудаас цөлжилттэй тэмцэх, гангийн нөлөөг бууруулах салбарт тухайлбал НҮБ-ын Бага хурлаар 1977 онд баталсан Цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад гаргасан хүчин чармайлт, хуримтлуулсан туршлагын ач холбогдол”-ыг өндрөөр үнэлсэн боловч, “өнгөрсөн хугацаанд цөлжилттэй тэмцэх, гангийн нөлөөг бууруулах талаар хүчин чармайлт гаргаж, зарим ахицад хүрсэн хэдий ч ... тавьсан зорилгодоо хүрээгүй”-г хүлээн зөвшөөрсөн билээ. Өмнөтгөлд “тогтвортой хөгжлийн зорилтыг хангах хүрээнд бүх түвшинд шинэ бөгөөд илүү үр дүнтэй алхам хийх шаардлагатай байгаа..”-г нэмж тодотгосон байна.

Африкийн орнуудын тэргүүлсэн хөгжиж байгаа улс орнууд 1992 оны Дэлхийн дээд хэмжээний уулзалтын бэлтгэл ажлын үеэр цөлжилтөд илүүтэй анхаарал хандуулах тухай шаардаж байсны үүний үр дүнд дэлхийн удирдагчид НҮБ-ын Ерөнхий ассемблеас хууль эрх зүйн хувьд заавал биелүүлэх үүрэг бүхий хуулийн хүчинтэй баримт бичгийг 1994 оны 6 дугаар сар гэхэд боловсруулсан байх үүрэг бүхий Засгийн газар хоорондын хэлэлцээрийн Хороог байгуулах тухай 21 дугаар зууны мөрийн хөтөлбөрт тусгаж өгсөн билээ.

Үүнээс 13 сарын дараа буюу Найроби, Женев, Нью Йорк, Парист хуралдсан таван удаагийн хүнд хэцүү хэлэлцээрийн дараа ажиглагчдын таамаглаж байснаас эсрэгээр, НҮБ-ын Ган цөлжилтөд ноцтой нэрвэгдэж буй орнуудын болон ялангуяа Африкийн цөлжилттэй тэмцэх тухай Конвенц (албан ёсны бүтэн нэр) –ийг 1994 оны 6 дугаар сарын 17-ны өдөр баталсан бөгөөд тэр жилийнхээ 10 сард гарын үсэг зурахад зориулж Парис-т дэлгэн тавьсан байна. 1995 оны 5 сар гэхэд 105 улс орон Конвенцид гарын үсэг зурсан байлаа.

Цөлжилтийн асуудлаар даян дэлхийн хэмжээнд нэгдэж ажиллах шаардлагын талаар хөгжингүй ба хөгжиж байгаа улс орнуудын хоорондоо байгуулсан гэрээ болох энэхүү Конвенц үүний өмнө хямралт байдлын эсрэг тэмцэж байсан оролдлогуудаас заавал биелүүлэх үүрэгтэй хуулийн баримт бичиг болохынхоо хувьд өөр юм. Энэхүү гэрээг соёрхон баталж нэгдэж орсон улс орон гэрээг биелүүлэх үүрэг хүлээнэ. Байгаль орчны чиглэлээр байгуулсан бусад гэрээ хэлэлцээрээс ялгаатай нь цөлжилттэй тэмцэх шаардлагатай үйл ажиллагааг нэн ялангуяа орон нутагт авч хэрэгжүүлэх тодорхой үүргийг улс орнуудад хариуцуулсан ба мөн түүнийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд мониторингийн хяналт тавих арга ажиллагаа, механизмд ихээхэн анхаарал хандуулсан байна. Даян дэлхийн дээд хэмжээний уулзалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд өнөөдрийн хувьд хүрсэн хамгийн чухал амжилтын нэг бол Конвенцийг эцэслэж гаргасан явдал бөгөөд ингэснээрээ Рио-гийн үзэл санааг бодит утгаар нь газарт буулгаж ирсэн юм.

4 Зарчмын асуудал

ЗОРИЛГО

Конвенцийн зорилго нь заавал биелүүлэх үүрэг бүхий хуулийн баримт бичгээр дамжуулж үүнд нэгдсэн Талууд урт хугацааны үүрэг хүлээх явдалд оршино. Конвенцийн зорилгыг “нэрвэгдэж буй бүс нутагт тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн 21 дүгээр зууны мөрийн хөтөлбөртэй нийцүүлэн цогц үйл ажиллагааны хүрээнд олон улсын хамтын ажиллагаа, түншлэлийн талаархи хэлэлцээрүүдийн дагуу бүх түвшинд үр дүнтэй арга хэмжээ авах замаар ган, цөлжилтэд ноцтой нэрвэгдэж буй улс орнууд, ялангуяа Африкт цөлжилттэй тэмцэх, ган гачгийн нөлөөг бууруулах, тэмцэл явуулахад оршино” гэж тодорхойлжээ. Цааш нь “Энэ зорилгод хүрэхийн тулд нэрвэгдэж байгаа газар нутгийн хүн амын амьжиргааны түвшин ялангуяа орон нутгийн хүн амын амьжиргааг дээшлүүлэх үүднээс газрын өгөөжийг нэмэгдүүлэх, газар ба усны нөөцийг зүй зохистой ашиглах, сэргээн сайжруулах, хамгаалахад чиглэсэн урт хугацааны иж бүрэн бодлого чухал болно” гэжээ.

Энэхүү Конвенц цөлжилт ба байгаль орчны тухай олон улсын хуулийг нэг цогц маягаар авч үзэж шинэлэг байдлаар ажиллана. Конвенц Засгийн газар, олон улсын хамтын нийгэмлэг, хөгжлийн ажилтнууд, орон нутгийн иргэд хоорондын шинэ хэлхээ холбоо бий болгох байдлаар зохион байгуулагдсан байна.

Конвенц 40 зүйл, бүс нутгийн дөрвөн Хавсралт (Африк, Ази, Латин Америк ба Карибийн тэнгис, ба Газар дундын тэнгисийн хойт хэсэгт конвенцийг хэрэгжүүлэх тухай) - тай бөгөөд “цөлжилттэй тэмцэх, гангийн нөлөөг бууруулах” гэсэн зорилтыг байнга давтсан байна. Цөлжилт хамгийн их гамшигийг дагуулж байгаа Африкт ихээхэн анхаарчээ. Түүгээр ч үл барам, Конвенцийн эх бичвэрийг баталсан Засгийн газар хоорондын Хэлэлцээрийн хорооны хуралдаанаар цөлжилтөд нэрвэгдэж байгаа Африкийн улс орнуудыг Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, хандивлагчдыг тэдэнд дэмжлэг үзүүлэхийг уриалсан, зөвхөн Африкт зориулсан тогтоолыг Конвенц албан ёсоор хүчин төгөлдөр болохоос өмнө баталж байсан байна.

Байгаль орчны тухай олон улсын хуулийн тухайд Конвенц ардчилсан, дороос гарсан саналыг дэмжих хандлагыг баримталсан анхны баримт бичиг болсон байна. Цөлжилтийн ачааг үүрч байгаа хүмүүс – өөрсдийн амьдарч байгаа эмзэг орчноо хамгийн сайн мэддэг хүмүүс – тэдний амьдрал нөлөөлөх шийдвэрийг гаргах үйл явцад бүрэн хамрагдах ёстой мөн оролцох эрхтэй байх тухай тодорхой зааж өгчээ. Гэрээний удирдлага болгох эхний зарчим нь Талуудад “цөлжилттэй тэмцэх, гангийн нөлөөг бууруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шийдвэр гаргахдаа хүн ам, орон нутгийн үүсгэл санаачилгын байгууллагуудыг оролцуулж, улс үндэсний болон орон нутгийн үйл ажиллагааг туслаж дэмжих тааламжтай орчинг бий болгох нөхцөлийг хангах” үүрэг хүлээлгэсэн байна.

Хоёр дахь зарчмын тухайд ч тэр, олон улсын хамтын ажиллагаа ба түншлэл (гаргаж байгаа хүчин чармайлтыг давхардуулахаас зайлсхийх, хандивлагчид ба тусламжийг хүлээж авч байгаа талуудын хооронд тогтсон нэг чиглэлийн уламжлалт харилцаанаас таггалзах) шаардлагатай болох тухай тодотгож өгсөн шинэлэг заалт байна. Конвенцид “Талууд олон улсын эв санааны нэгдэл, түншлэлийн уур амьсгалаар дэд бүс, бүс нутаг, олон улсын түвшинд хамтын ажиллагаа ба зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай тэр газарт нь санхүү, хүн, хүч, зохион байгуулалт, техникийн нөөцийг илүү үр ашигтай төвлөрүүлэх шаардлагатай” гэжээ.

Конвенцийн удирдлага болгож байгаа гурав дахь зарчим нь цөлжилтөд нэрвэгдэж байгаа орнууд хоорондын түншлэл харилцан ашигтай хамтын ажиллагаа зарчмыг улам бүр өргөжүүлж өгсөн байна. “Талууд нэрвэгдэж байгаа бүс нутгийн газрын байдал, үнэ цэнэ, усны нөөцийн хомсдол

КОНВЕНЦИЙН ТАЛ БОЛЖ НЭГДЭЖ ОРСОН ЦӨЛЖИЛТӨД НЭРВЭГДЭЖ БҮЙ УЛС ОРНУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

Конвенцид нэгдэж орсон цөлжилтөд нэрвэгдэж буй орнууд доорхи үүргийг хүлээнэ. Үүнд:

- a) цөлжилттэй тэмцэх, ган гачгийн нөлөөллийг бууруулахад дээд зургийн анхаарал тавьж, өөрсдийн үүрэг, бололцооныхоо хирээр боломжийн хөрөнгө нөөцийг гаргах;
- b) тогтвортой хөгжлийн төлөвлөгөө, бодлогын хүрээнд цөлжилттэй тэмцэх ба ган гачгийн нөлөөллийг бууруулах асуудалд нэн тэргүүний ач холбогдол өгч, чиг бодлогоо боловсруулах;
- c) цөлжилт үүсэх шалтгааныг арилгах асуудлыг авч үзэж, цөлжилтийн үйл явцад нөлөөлж байгаа нийгэм эдийн засгийн хүчин зүйлд онцгой анхаарал хандуулах;
- d) орон нутгийн хүн амыг мэдээллээр хангах, тэднийг ялангуяа эмэгтэйчүүд, залуучуудыг төрийн бус байгууллагуудын дэмжлэгтэйгээр цөлжилттэй тэмцэх, ган гачгийн нөлөөллийг бууруулах үйл ажиллагаанд оролцуулахад нөлөөлөх;
- e) одоо үйлчилж байгаа хууль тогтоомжийг чангатгах, байхгүй бөгөөд нэн шаардлагатай хуулийг шинээр гаргах, урт хугацааны бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг буй болгох тааламжтай орчин бүрдүүлэх.

тэдгээрийг зүй зохистой ашиглах зэрэг асуудлыг илүү гүнзгий ойлгох хэмжээнд хүрэхийн тулд удирдлагын бүх түвшин, үүсгэл санаачилга, төрийн бус байгууллагууд, газар эзэмшигчдийн хоорондын хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх” ёстой гэж Конвенцид заажээ.

Дөрөв дахь буюу хамгийн сүүлийн зарчим “Талууд нь Конвенцийн Талууд болох нэрвэгдэж буй хөгжиж байгаа орнууд тухайлбал, ядуу буурай орнуудын онцгой хэрэгцээ, нөхцөл байдлыг бүрэн хэмжээнд харгалзаж үзэх ёстой” гэжээ.

Энэхүү Гэрээний эхэнд цөлжилттэй тэмцэх, ган гачгийн нөлөөллийг бууруулах хөтөлбөрүүдийг бие биенээс саланги байдлаар авч үзэж болохгүй бөгөөд харин ч хөгжлийн бодлогуудтай нягт уялдсан нэг цогц зүйл байх тухай өгүүлсэн байна. “Цөлжилт ба ган гачгийн үйл явцын физик, биологи, нийгэм-эдийн засгийн төлөвт иж бүрэн хандах” шаардлагатай тухай анхааруулсан байна.

Конвенц олон улсын болон тухайн улсын дотоодын эдийн засгийн орчинд тусгайлан анхаарал хандуулж, цөлжилттэй үр дүнтэй өгөөж ихтэй тэмцэх бололцоог гаргах, үүнийг зохион байгуулах шаардлагатайг тодорхой өгүүлсэн байна. Талууд худалдаа, зах зээлийн орчин, өрийн асуудал цөлжилтөд нэрвэгдэж байгаа улс орнуудад хэрхэн нөлөөлж байгаа тухайд “онцгой анхаарал” хандуулах үүрэг хүлээсэн бөгөөд үүнд “тогтвортой хөгжилд тус дэм үзүүлэх, олон улсын эдийн засгийн тааламжтай нөхцөлийг бий болгох” явдал орно гэжээ.

Цөлжилтийн эсрэг авч хэрэгжүүлэх хүчин чармайлтыг “ядуурлыг таслан зогсоох стратеги”-тай уялдуулах үүрэг хүлээсэн байна.



КОНВЕНЦИЙН ТАЛ БОЛЖ НЭГДЭЖ ОРСОН ХӨГЖИНГҮЙ УЛС ОРНУУДЫН ХҮЛЭЭХҮҮРЭГ

Конвенцийн Тал болж нэгдэж орсон хөгжингүй улс орнууд доорхи үүргийг хүлээнэ. Үүнд:

- а) Цөлжилтөд нэрвэгдэж буй Конвенцийн тал болох хөгжиж байгаа орнууд ялангуяа Африкийн орнуудын цөлжилттэй тэмцэх ба ган гачгийн нөлөөллийг бууруулах талаар тавьж буй хүчин чармайлтыг тохиролцооны дагуу дангаараа болон хамтран идэвхтэй дэмжих;
- б) Цөлжилтөд нэрвэгдэж буй Конвенцийн тал болох хөгжиж байгаа орнууд ялангуяа Африкийн орнуудын цөлжилттэй тэмцэх, гангийн уршигийг бууруулах өөрсдийнхээ урт хугацааны төлөвлөгөө, чиг бодлогыг үр дүнтэйгээр боловсруулж хэрэгжүүлэхэд нь үлэмж хэмжээний санхүүгийн эх үүсвэрийг дайчлах, бусад хэлбэрийн тусламж үзүүлэх;
- в) 20 дугаар зүйлийн 2 дугаар заалтын дагуу санхүүгийн шинэ, нэмэлт эх үүсвэрүүдийг дайчлахад нь туслах
- д) хувийн сектор, төрийн бус бусад эх үүсвэрээс санхүүгийн нөөц боломжийг дайчлах явдлыг хөхүүлэн дэмжих;
- е) Конвенцийн Тал болон нэгдэн орсон цөлжилтөд нэрвэгдэж буй орнууд ялангуяа хөгжиж байгаа орнуудад холбогдох технологи, мэдлэг, ноу-хау-г олж авах боломж олгох, дэмжлэг үзүүлэх.

Конвенцоор хүлээх нийтлэг үүрэгт хамтын ажиллагаа тэр дундаа засгийн газрын байгууллага хоорондын, бүс нутаг хоорондын, дэд бүс хоорондын, олон улсын хэмжээний хамтын ажиллагааны ач холбогдолтой болохыг зааж өгсөн байна. Нийтлэг үүрэгт мөн “байгаль орчин ба газар, усны нөөцийг хамгаалах талаар цөлжилтөд нэрвэгдэж байгаа Конвенцийн Талууд хоорондын хамтын ажиллагааг ган, цөлжилттэй

тэмцэхэд түлхүү чиглүүлэх” тухай заасан байна. Цөлжилтөд нэрвэгдэж байгаа ба хөгжингүй улс орнууд энэхүү Конвенц-д нэгдсэнээр тодорхой үүрэг хүлээж хэрэгжүүлэх учиртай болж байна (хайрцагласан мэдээллийг үзнэ үү). Конвенц хувийн хэвшлийн ач холбогдлыг үнэлж, олон нийт ялангуяа төрийн бус байгууллагуудын конвенцийн хэрэгжилтэнд оролцох үүргийг ихээхэн өндөрсгөсөн байна байна.

Мөн шинжлэх ухаан, технологийн хүчин чармайлтыг өөр зүг рүү чиглүүлж тухайлбал, нутгийн иргэд шинжлэх ухааны ашиг тусыг хүртэх, түүнд өөрийн ач тусыг нэмэрлэх асуудалд анхаарлаа хандуулсан байна. Конвенцид уян хатан, боломж ихтэй хяналтын механизм бийгээс гадна улс хоорондын болон олон улсын байгууллага хоорондын хамтын ажиллагааг хангах заалтууд оржээ.



Цөлжилттэй тэмцэх стратеги нь системтэй ба нухацтай хийсэн ажиглалт мөн шинжлэх ухааны гүн бат мэдлэг дээр тулгуурласан цагт илүү үр дүнтэй байх болно.

5 ТУСЛАМЖ ДЭМЖЛЭГЭЭС ХАМТЫН АЖИЛЛАГАА РУУ

Энэхүү Конвенц нь тусламж дэмжлэг гэхээсээ илүү хамтын ажиллагааг тодотгосон эрх зүйн хувьд заавал биелүүлэх ёстой магадгүй хамгийн анхны баримт бичиг мөн болов уу. Өдийг хүртэл, цөлжилттэй тэмцэх хүчин чармайлт нь хөгжлийн бусад бүхий л санал санаачлагуудын нэгэн адил ерөнхийдөө нэг талыг барьсан харилцаагаар зохицуулагдаж байсан билээ.


Цөлжилтөд нэрвэгдэж байгаа улс орнууд хөгжингүй улс орнуудаас тусламж дэмжлэг хүснэ. Зарим тохиолдолд, цөлжилтөд нэрвэгдсэн улс орнууд хөтөлбөр, төслийн санал боловсруулаад дараа нь түүндээ санхүүжилт хайна. Зарим тохиолдолд хөгжингүй улс орнууд өөрсдийн тусламж дэмжлэгийн нэг нөхцөл болгож тодорхой хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахыг шаарддаг байна.

Түүнээс гадна нэг талыг дагасан үйл явц нэрвэгдэж байгаа улс орнуудын доторч явагддаг байна. Төв засгийн газраас цөлжилтийн аюулд өртөж байгаа хүмүүст ихэнх тохиолдолд тусламжийг хэрхэн зарцуулах тухай шийдвэрийн талаар тэдэнтэй зөвлөлдөлдөлийгээр эсвэл тэднийг оролцуулалгүйгээр хүргүүлнэ.

Нэг талыг барьсан эдгээр хандлага бүрэн утгаараа ажиллаж чадахгүй байсан бөгөөд энэхүү Конвенц хамтын ажиллагааг конвенцийг хэрэгжүүлэх хамгийн орчин үеийн арга болгож тунхагласан байна. Үүгээр “олон улсын түншлэл, хамтын ажиллагаа нь ач холбогдолтой бас шаардлагатай” тухай тодорхойлж, үндэсний төлөвлөгөөг “хандивлагчид, бүх түвшний засгийн газрууд, орон нутгийн иргэд, үүсгэл санаачлагын байгууллагууд хоорондын хамтын ажиллагаан түншлэл”-ийн үзэл санаагаар хэрэгжүүлэх шаардлагатайг тэмдэглэсэн байна.

Бодит байдал дээр бол Үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийг ардчилсан зарчмаар гэхдээ бүх талын оролцоотой ихээхэн ярвигтай үйл явцын үр дүнд боловсруулан гаргадаг бөгөөд үнд гадаадын хандивлагчид (хоёр талт болон олон талт аль аль нь хамаарах), бүс нутгийн байгууллагууд, үндэсний ба орон нутгийн засгийн газрууд, төрийн бус байгууллагууд, орон нутгийн иргэд бүгд хамрагдаж хамтран ажиллах ёстой. Төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлэх талаар харилцан тохирсон Хамтын ажиллагааны гэрээг байгуулна. Ингэснээр хөтөлбөр, тэргүүлэх чиглэлийн аль аль нь хамтын ажиллагааны үр дүнд тодорхой болох ба нэг нь нөгөөдөө тулган хүлээлгэх асуудал гарахгүй. Ямар нэгэн ажлыг давхардуулан хийх асуудал гарахгүй, зохицуулалтыг хангасан учраас энэ нь илүү үр дүнтэй, тэгш эрхийг хангасан ардчилсан шинжтэй болох юм.

Энэ үзэл санаа конвенцийн бүх хэсэгт тусгалаа олсон байна. Тухайлбал, Африкийн бүс нутагт конвенцийг хэрэгжүүлэх Хавсралтад “үндэсний, дэд бүсийн, бүс нутгийн түвшинд зөвлөлдөх үйл явцыг зохион байгуулах” тухай өгүүлээд энэ нь “үндэсний, дэд бүсийн, бүс нутгийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тулгуурласан хамтын ажиллагааны гэрээг хэлэлцэх, түүнийг байгуулах чуулга уулзалтын үүргийг гүйцэтгэж болох юм” гэжээ.



6 Дороос дээш үйлчлэх хандлага

Цөлжилттэй холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бий болгох шаардлагатай хамгийн чухал хамтын ажиллагааны хэлбэр бол хандивлагчид, улс орны засгийн газрууд, орон нутгийн засаг захиргааг, хуурай гандуу газар нутгийн ард иргэд өөрсдийнх нь хоорондын хамтын ажиллагаа юм. Он жилүүд урсан өнгөрсөөр байх хооронд, олон олон төсөл хөтөлбөрийг үр ашиггүй хэрэгжүүлсээр байх хооронд, асуудал улам бүр хурцадсаар байх хооронд цөлжилтийн нөлөөлөлд хамгийн ихээр өртөж байгаа хүмүүс бүрэн хэмжээгээр оролцохгүйгээр сэтгэл санаагаа бүрэн зориулахгүй байх нь цөлжилтийн асуудлыг үр дүнтэй шийдвэрлэж чадахгүй юм.

Хуурай гандуу газар нутаг бүхий хөгжиж байгаа улс орны иргэд бол хамгийн үнэтэй нөөц бололцоо юм. Тэд л өөрсдийн газар нутгаа хэнээс ч илүү мэднэ. Тэд бол Америкийн үр тариа үйлдвэрлэгчид эсвэл Хятадын цагаан будаа тариалагчидын нэгэн адил амьдралаа хэрхэн авч явах арга ухааныг эзэмшсэн хүмүүс. Зарим тохиолдолд тэдний амьдралын арга барил, илүү эмзэг хөрстэй, илүү хатуу ширүүн уур амьсгалтай, нөөц бололцооны боломж хамаагүй бага байдаг илүү хүнд хэцүү нөхцөл байдалд ажиллах ёстой болдог, учраас илүү ч байж болох юм. Тэд бол цөлжилттэй тэмцэхэд шаардагдах хамгийн үнэтэй хамгийн чухал байж болох өв юм.

Гэлээ ч гэсэн, дээхэн үедээ тэднийг ихэвчлэн анхаарлын гадна үлдээж байсан ба тэр ч байтугай цөлжилтийн буруутан хэмээн шүүмжилж байлаа. Колонийн засаг захиргаа нөхцөл байдал маш өөр байдаг, өөрийн уугуул нутагтаа боловсруулсан шийдэлийг тулгах явдал байнга тохиолдож байлаа: шинээр байгуулагдсан Засгийн газар түүнийг нь хэрэгжүүлэхээр шамдаж байх нь олонтаа тохиолдож байв. Газар ашиглах уламжлалт хуучин аргыг тасалдуулах явдал байнга хамгийн тохиолдож үүнээс шалтгаалж хуурай гандуу газар нутгийн нүүдэлчид болон бусад хүмүүс амь амьжиргаагаа орхихоос аргагүй болж байв. Гаднаас зээлж авчирсан шийдэл олигтой ажиллахгүй байхад нутгийн хүмүүс гадуурхагдаж ингэснээр тэдний ядуурал улам бүр газар авч байлаа. Ямар нэгэн төслийн хэрэгжилтийн үр дүнд ашиг шим хүртэх ёстой хүмүүс нь тэрхүү төслийг хурдхан дуусахыг, мөн гадны хүмүүсийг зайлахыг хүлээж ингэснээр өөрсдийн өдий хүртэл явж ирсэн замналаараа аж ахуйгаа хөтлөхийг хүсэх нь тохиолдож байлаа. Маш олон тохиолдолд 2 юм уу 3 жилийн дараа гэхэд л нөгөө хэрэгжүүлж байсан ажлынх нь бараг ул мөр ч үлдэхгүй байх нь бий.

Гэлээ ч гэсэн зарим төслүүд амжилтанд хүрсэн байх нь бий: ихэнх тохиолдолд ийм төслийг орон нутгийн иргэдийн хүсэл сонирхлыг сонсож чадсан, тэдний арга ажиллагаа, сонирхлоос суралцсан, тэдэнтэй хамтарч шийдэл гаргасан байгууллага хэрэгжүүлсэн байна. Энэ нь хуурай гандуу газар нутгийн ард иргэд өөрсдийнх нь амьдралд сөргөөр нөлөөлж байгаа асуудлыг шийдвэрлэхэд бүрэн оролцох боломжтой байх ёстой тухай санааг улам эрчимжүүлж бодит ажил болоход ихээхэн түлхэц болсон юм.

“Оролцоо” гэдэг ойлголт олон жилийн турш байж л байсан санаа л даа. Гэхдээ ихэвчлэн хуучны “дээрээс доошоо” гэсэн санаатай ямар нэгэн байдлаар цуг явж ирсэн байдаг: хөтөлбөрийн холбогдолтой шийдвэрийг хаа нэгтээ гаргасныхаа дараа орон нутгийн хүмүүсийг урих эсвэл тэдэнд хөтөлбөрт хамрагдах талаар хэлж байсан байна. Жинхэнэ оролцоо гэдэг бол хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад түүний нөлөөнд өртөх болдог орон нутгийн иргэд өөрсдөө шийдвэр гаргах асуудал бөгөөд ингэснээр шийдвэр гарсны дараа түүнийг амьдралд хэрэгжүүлэх итгэл үнэмшил, хүчин чадлыг тэдэнд олгох болохоос тэдэнд зориулсан байх учиртай биш юм.

Эмэгтэйчүүдийн оролцоог хангахын тулд тусгай арга хэмжээ авах хэрэгтэй бөгөөд үүний учир нь эмэгтэйчүүд өөрснийхөн дотроо ч тэр цөлжилтэнд хамгийн ихээр нэрвэгдэж байдаг мөртлөө үүний эсрэг ямар нэгэн арга хэмжээ авах чадавхи мөхөс байдагтай холбоотой болно. Эмэгтэйчүүд газар дээр бүх л ажлыг хийдэг боловч тэдний дуу хоолой өөрснийхөн дотроо ч сонсогддоггүй: тусламж, зөвлөгөө, харилцаа холбоо зэрэг гаднаас



Үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийг оролцооны аргаар боловсруулах болно

ирэх зүйлс ихэвчлэн эрэгтэйчүүд рүү л чиглэсэн байдаг байна.

Конвенц доороос дээшээ чиглэсэн хандлагыг олон улсын хуулинд суулгаж өгснөөрөө цоо шинэ орчинг бий болгосон байна. Бүрэн оролцооны ач холбогдолтой болох тухай конвенц дахин дахин давтаж байгаа ба “эмэгтэйчүүдийн гүйцэтгэж байгаа үүргийн ач холбогдол”-ыг тусгайлан тодотгож өгчээ. Түүнээс гадна конвенц “төрийн бус байгууллагуудын гүйцэтгэх онцгой үүрэг”-т ач холбогдол өгч, конвенцийн хэрэгжилтэд тэд чухал үүрэг гүйцэтгэхийг дурьдсан байна.

Талууд “орон нутаг, улс үндэстэн, бүс нутгийн түвшинд бодлого боловсруулах, шийдвэр гаргах, үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, дүн шинжилгээ хийхэд төрийн бус байгууллагууд, эрэгтэй эмэгтэй ялгаагүй орон нутгийн иргэд, ялангуяа байгалийн нөөцийг ашиглагч нар түүний дотор тариачид, малчид, тэдгээрийн төлөөлийн байгууллагуудыг оролцуулах” үүргийг хүлээж байна. Энэ асуудлын өгүүлэмж Конвенцийн турш дурьдагдаж байна. Тухайлбал, Африкийн улс орнууд өөрсдийн бүс нутагт конвенцийг хэрэгжүүлэх тухай Хавсралтдаа “орон нутгийн хүн ам ба бүлэглэлийг дээд зэргээр хамрах боломж олгохуйц уян хатан төлөвлөлтийн бодлогыг боловсруулахын тулд зохих түвшний захиргааны байгууллага, нутгийн хүн ам, тэдгээрийн бүлэглэлүүд болон төрийн бус байгууллагуудыг оролцуулан заавар, зөвлөлгөө өгөх ажлыг өргөн хэрэгжүүлнэ”. Тэд үйл ажиллагааны Үндэсний хөтөлбөртөө “эмэгтэйчүүд, тариаланчид, малчдыг оролцуулан нутгийн хүн ам, бүлэглэлийн оролцоог өргөтгөх тэдгээрт менежментийн илүү өргөн эрх олгох” үүргийг бас хүлээсэн байна. Түүнээс гадна конвенцид нэгдэн орсон Ази тивийн Талууд хавсралтдаа “орон нутгийн захиргааны байгууллагууд, холбогдол бүхий үндэсний ба төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааны зөвлөлдөөний явцад орон нутгийн хүн амын бүлэглэлийг хамруулан нэрвэгдэж буй хүн амыг үндэсний хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулахад татан оролцуулах”-аар тохирсон байна.

7 Хамдтаа ажил хэрэг болгоё

Конвенци нь “Давхардлаас сэргийлж, тусламжийн үр ашигт чанарыг хамгийн их болгох зорилгоор хөгжиж буй орнууд, хөгжингүй орнууд, холбогдох Олон улсын Засгийн газрууд, Төрийн Бус Байгууллагууд хоорондын удирдлага, зохицуулалтыг хамгийн дээд зэргээр хийх хэрэгтэй” гэж үзэж байна. Ингэхийн тулд Талууд нь ялангуяа үндэсний болон орон нутгийн түвшинд “үйл ажиллагааны механизм”-ыг боловсруулан хэрэгжүүлэх ёстой. Байгаа нөөцийг үр дүнтэй ашиглах, хүлээн авсан тусламжаас илүү их үр ашгийг хүртэх, цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, конвенцийн хүрээнд тулгамдсан асуудлуудын хэрэгжилтийг хангахын тулд Олон улсын хамтын ажиллагаатай холбоотой үйл ажиллагааг удирдан чиглүүлэх явдал нь Цөлжилтөнд өртсөн хөгжиж буй орнуудын Талуудын хувьд нэн тэргүүний асуудал болж байна.

Цөлжилт, ган хуурайшилттай тэмцэх ихэнх оролдлого, хүчин чармайлт нь энд тэнд, тархмал байдалтай, хандивлагч, яамд, төсөл зэрэг нь өөр хоорондоо өрсөлдсөн, салангид үйл ажиллагаа мэт болсон байна. Хандивлагч орон, байгууллагууд нь хүлээн авагч Засгийн газрыг тэдний тусламж, дэмжлэгийг авахад зориулсан шинэ төлөвлөгөөг боловсруулахад хүргэдэг ба тэдгээр нь гол төлөв тухайн Засгийн газрын бусад хандивлагчидтай ажиллаж, хэрэгжүүлж байсан төлөвлөгөө, хөтөлбөртэй маш бага уялдсан байдаг. Хандивлагчид нь тухайн хөтөлбөр, төлөвлөгөөг зөвхөн хэсэгчлэн санхүүжүүлдэг бөгөөд хандивлагч нь хуучин төлөвлөгөөг үргэлжлүүлэх бус харин бүхнийг эхнээс нь эхлүүлэхийг хүсдэгтэй холбоотойгоор тэдгээр нь хэзээ ч бүрэн дүүрэн хэрэгждэггүй байна.

Тиймээс Конвенци улс орнууд, хандивлагч, олон улсын байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа, удирдлага зохицуулалтыг чухалчилж, цаашид ийм давхардал, үр ашиггүй байдлыг үргэлжлүүлэн гаргах явдлыг зогсоохыг зорьж байна. Улмаар улс орнуудын түншлэлийн харилцааг чухалчилж, Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйлст холбогдох бүх талууд хамтран зүтгэж, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар хамтдаа шийдвэр гаргах хэрэгтэй гэдгийг Конвенци цохон тэмдэглэж байна.

Конвенци нь: “Улс орнуудын Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр нь, удирдлага, зохицуулалт, хамтын ажиллагааг хангах эрх, үүрэг бүхий байгууллагын удирдлага зохион байгуулалтыг бэхжүүлж, хандивлагч бүлэг, бүх түвшний удирдах байгууллага, орон нутгийн ард иргэд, нөхөрлөл, бүлгүүдийн хоорондын түншлэлийн хамтын ажиллагааг дэмжих бодлогын баримт бичиг байх учиртай” гэж үзэж байна.

Конвенцийн Талууд урт хугацааны төлөвлөлт бүхий үйл ажиллагааны хөтөлбөрийг төлөвлөн, боловсруулж, түүний хэрэгжилтийг хангаж, санхүүжүүлэх зорилгоор “санхүүгийн хамтын ажиллагаа”-г өрнүүлнэ хэмээн бие биедээ амлалт өгч байна. Цаашилбал Талууд нь Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, боловсруулахдаа холбогдох Засгийн газар хоорондын байгууллагаар дамжуулан буюу шууд байдлаар өөр хоорондоо холбогдон, хамтдаа, ойр дотно ажиллана гэдэгт санал нэгдэж байна. Тэд Конвенцийн өмнө хүлээсэн ерөнхий чиг үүргийн хүрээнд байгаль орчин, газар, усны нөөцийг хамгаалахад цөлжилтөнд өртсөн орнуудын хамтын ажиллагааг өрнүүлэн чиглүүлэх болон дэд бүсийн, бүсийн болон олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд хүчин зүтгэнэ. Африкийн орнуудын Талууд нь: “Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг тогтвортой хөгжлийн үндэсний бодлогын “төв буюу түүний салшгүй нэг хэсэг” болгон боловсруулна” хэмээн Конвенцийг Африкийн бүс нутагт хэрэгжүүлэх

тухай хавсралтандаа санал нэгдэж оруулсан байна. Конвенцийн бүх Талууд цөлжилттэй тэмцэх, гангийн нөлөөг бууруулах талаар олон нийтэд таниулан сурталчлах, боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ Засгийн газар хоорондын байгууллага, түүнчлэн Төрийн Бус Байгууллагаар дамжуулан өөр хоорондоо хамтран ажиллана хэмээн санал нэгдсэн байна.

8 Хүрээгээ өргөжүүлэх нь

Цөлжилттэй тэмцэх ихэнх оролдлого, хүчин зүтгэл нь цөлжилтийн шалтгаанаас илүүтэй цөлжилтийн илрэх хэлбэр, шинж тэмдэгт илүү их анхаарч үзсэн байна. Тэдгээр нь цөлжилтийн сөрөг үр дагаварыг бууруулахад анхаарч, тэрхүү сөрөг үр дагаварыг улам даамжруулж буй хүний буруутай үйл ажиллагааг бууруулахад чиглэгдсэн байна.

Тиймээс хэт их ургац тариалах, бэлчээрийн даац хэтрүүлэх, ойгүйжүүлэлт болон зүй бус усалгааны асуудлуудыг шийдвэрлэхэд анхаарч, харин тэдгээрийг бий болгоод байгаа цаад шалтгаан болох нийгэм, эдийн засгийн дарамтуудыг шийдвэрлэхэд төдийлөн анхаардаггүй байсан байна. Өөрөөр хэлбэл, цөлжилт үүсэх шаалтгаан болж буй хүмүүсийн газрыг хэт ихээр ашиглахад хүргэж буй тэдний энэхүү үйлдлийн цаад гадны хүчин зүйлсийг олж тогтоон, шийдвэрлэхийн оронд тэднийг буруутган, зэмлэж байна.

Ийнхүү асуудалд маш өнгөцхөн хандаж, шийдвэрлэх гэж оролдсоны улмаас өнгөрсөн хугацаанд дорвитой ахиц, ололтонд хүрч чадахгүй байсан. Үүний нэг тод жишээ бол 1977 онд баталсан “Цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааны хөтөлбөр” бөгөөд тус хөтөлбөр бүрэн хэрэгжих боломжгүй болсон юм. Конвенци нь дээрх байдлыг засан сайжруулж, цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааны хамгийн чухал хэсэг буюу “зүрх” нь болох аливаа цөлжилттэй тэмцэх дүн шинжилгээ, хөтөлбөрийн хэрэгжилтэнд нийгэм-эдийн засгийн асуудлуудыг нэгтгэн цогцоор авч үзэж, цөлжилтийн физик болон биологийн хүчин зүйлст энэ тэнцүү ач холбогдол өгч анхаарах болсон байна.

Цөлжилтөнд өртсөн улс орнуудын Талууд нь Конвенцийн өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу цөлжилтийн шалтгаануудыг олж тогтоон, шийдвэрлэх, цөлжилтөнд нөлөөлж буй нийгэм-эдийн засгийн хүчин зүйлүүдэд тусгайлан анхаарч ажиллаж байна.

Конвенцийн бүх Талууд нь цөлжилт, гангийн үйл явцын физик, нийгэм-эдийн засаг, биологийн асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн нэгдсэн арга хандлагыг хүлээн зөвшөөрч, ажиллах үүрэгтэй. Ялангуяа, тэд ядуурлыг үндсээр нь арилгахыг цөлжилттэй тэмцэх, гангийн нөлөөг бууруулах хүчин чармайлттай нэгтгэсэн “нэгдсэн стратеги”-тэй байх амлалтыг өгөөд байна.

Ядуурал нь хүмүүсийг тэдэнд байгаа жаахан газраа аль болох чадах хэмжээгээрээ ашиглахаас өөр аргагүй байдалд хүргэж, өнөө маргаашаа аргацаасан, зөвхөн амьдралын анхны хэрэгцээгээ хангахын төлөө л хичээн амьдрахад хүргэж байна. Ядуу хүмүүст ямар ч сонголт байхгүйн улмаас урт хугацаанд, ирээдүйд яах талаар бодож, төлөвлөж, газрыг тогтвортой ашиглах талаар бодох боломж байдаггүй. Тиймээс аливаа үр ашигтай стратеги бол ядууралтай тэмцэх асуудлыг “гол төв”-өө болгосон байдаг.

Ийм стратеги нь улс орны нийгмийн асуудал, газар эзэмшигчдийн асуудлыг анхаарч үзэж, шийдвэрлэсэн байх учиртай ба ялангуяа хүн амын боловсрол, сургалт, тээвэр, харилцаа холбооны асуудлыг хүртэл бодолцож, бүх асуудлуудыг нэгдмэл, шлгц байдлаар авч үзсэнээр цөлжилттэй идэвхитэй, үр дүнтэй тэмцэх нөхцөл бүрдэнэ. Үндэсний болон олон улсын томоохон төлөвлөгөө, стратегиуд нь тухайн бүс нутгийн орон нутгийн иргэдийн тавьж буй бүхий л шийдвэрүүдтэй холбогдож, уялдсан байх ёстой. Орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүд нь цөлжилтөнд нэрвэгдсэн газруудад хийх хөрөнгө оруулалт, чадавхийг бүрдүүлэх асуудлг цогц, байгаа байгалийн нөөцөө удирдан, зохицуулах чадавхийг орон нутгийн иргэдэд бий болгох асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн байх учиртай.



9 Нөхцөл бүрдүүлэх

Цөлжилтөнд өртсөн орнууд, хуурай, хуурайвтар, чийг дутмаг газрын хүн амын хувьд цөлжилтийг үр дүнтэй даван туулахын тулд юуны түрүүнд түүнтэй тэмцэх нөхцөл бололцоог зөв зүйтэй тавьж өгөх ёстой юм. Улс орны эдийн засаг, физик хүчин зүйлийн сөрөг нөлөөг дөнгөн данган даван туулж, тэсч үлдэхийн төлөө зүтгэж буй Засгийн газар, орон нутгийн иргэдийн хувь хямралд илүү их анхаарал хандуулах нь хүндрэлтэй юм. Конвенци нь “хүрээлэн буй орчныг чөлөөлөх”-д илүү их анхаарах хэрэгтэйг чухалчлан, ингэснээр тогтвортой хөгжил бий болох боломж бүрэдэнэ гэж үзэж байна.

Үндэсний түвшинд “хүрээлэн буй орчноо чөлөөлөх” гэтэгт сайн засаглал, тогтвортой байдал, хууль эрх зүй, засаг захиргааны шинэчлэл, эдийн засгийн хөшүүрэг, дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг асуудлууд бүгд орж байна. Тиймээс хүрээлэн буй орчноо чөлөөлөхийн тулд өнөөгийн хөгжиж буй олон орнуудын эдийн засагт тулгамдаж буй асуудлуудыг өөрчлөх шаардлагатай байна.

Энэхүү өөрчлөлтийг хэсэгчлэн хийж болох ба тухайлбал хүн амын амьжиргааг дээшлүүлэх эдийн засгийн боломжит хувилбаруудыг хэрэгжүүлэх замаар газарт үзүүлэх дарамтыг багасгаж болох юм. Энд мөн тосгоны ойн схемийг боловсруулан гаргах, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах, зэрлэг ан амьтанд суурилсан аялал жуулчлалыг хөгжүүлэх зэрэг хувилбаруудыг хэрэгжүүлж болох юм.

Орон нутгийн иргэд өөрсдийн газраа ашиглах тэгш бөгөөд бүрэн эрхтэй байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, газрыг орон нутгийн иргэдэд эзэмшүүлж, иргэд нь тэднээс газрыг нь авна гэдгээс айдаггүй байх нөхцлийг бүрдүүлж өгвөл тэд газраа хайрлан хамгаалж, зүй зохистой ашиглах болно. Конвенцийг Африкийн бүсэд хэрэгжүүлэх тухай хавсралтанд Африкийн Талууд нь: Орон нутгийн иргэдэд газрыг түр эзэмшүүлэх, газар эзэмших эрхийн аюулгүй байдлыг нь хангах байгалийн нөөцийн менежментийн зохицуулалтын хүрээ, зохистой бүтэц зохион байгуулалтыг бий болгоход санал нэгдэж байна.

Олон улсын эдийн засгийн хүчин зүйлс нь “тогтвортой бус хөгжлийг” бий болгох шалтгаан болж байна хэмээн Конвенцийг Латин Америк, Карибын сав нутагт хэрэгжүүлэх тухай хавсралт онцолж байна. Өнгөрсөн 20 жилд гарсан улс орнуудын өр төлбөр, худалдааны



тогтворгүй байдал ба доройтол, үнийн хязгаарлалт хийх болон тогтсон үнэ байхгүй байх, бүтэц зохион байгуулалтын хөтөлбөрүүд нь бүгд тухайн улс орныг өөрсдийн газраа илүү ихээр ашиглахад хүргэсэн байна. Зарим хөгжингүй орнуудаас үзүүлэх хоол хүнсний тусламж нийлүүлэлт нь хөгжиж буй орнуудын дотоод дахь хөдөөгийн тариачдын зах зээлийг сүйтгэдэг байна.

Талууд нь цөлжилтөнд өртсөн, хөгжиж буй орнуудын Талуудын нөхцөл байдалд ихээхэн анхаарал хандуулж, ялангуяа тэдний олон улсын худалдаа, зах зээлийн зохицуулалт, тогтвортой хөгжлийг бий болгохд нийцсэн олон улсын эдийн засгийн орчинг бүрдүүлэх болон тэдгээрийн өр төлбөрийн асуудалд ихээхэн анхаарч байна.

Талууд нь цөлжилтийг бий болгож буй үндсэн шалтгааныг шийдвэрлэж, түүнд нөлөөлж буй нийгэм-эдийн засгийн хүчин зүйлд маш их анхаарч ажиллана хэмээн бие биедээ амлалт өгч байна.

10 Үйл ажиллагааны хөтөлбөрүүд

ХҮСНЭГТ 1

Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрт тавигдах үндсэн шаардлагууд нь:

- “Урт хугацааны стратегийг уялдан байх, тогтвортой хөгжлийн үндэсний бодлоготой нэгдмэл байх ба хэрэгжилтийг онцлон тодорхойлсон байх
- Өөрчлөгдөн хувьсаж буй нөхцөл байдалтай уялдуулан өөрчлөлт, засварыг хийж болох ба нийгэм-эдийн засгийн, биологийн болон газарзүйн өөр өөр нөхцөл байдлаас шалтгаалан орон нутгийн түвшинд энэ нь уян хатан өөрчлөгдөж байх
- Доройтоогүй байгаа буюу маш бага хэмжээгээр доройтож эхэлж байгаа газрыг цөлжихөөс урьдчилан сэргийлж, хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд илүү анхаарсан байх
- Үндэсний цаг агаар, гадаргын ус, уур амьсгалын хэлбэлзлийг тодорхойлох хүчин чадлыг нэмэгдүүлэх, улмаар гангаас урьдчилан сэрэмжлүүлэх системийг бий болгох
- Хамтын ажиллагаа, нэгдсэн зохицуулалтыг хийх, орон нутгийн иргэд зохистой мэдээлэл, технологийг ашиглах боломжийг хангаж, удирдан чиглүүлэх байгууллага, институтыг бэхжүүлэх, бодлогоор хангах
- Орон нутагт, үндэсний, бүсийн түвшинд үр дүнтэй оролцоог хангах
- Үйл ажиллагааны явцын тайланг гаргах, тэдгээрийн хэрэгжилтэнд байнгын хяналтыг тавьж байх

нягт уялдуулан, тухайн нөхцөл байдалд дасан зохицож нийцүүлэн байдлаар ЦТҮХ-өө боловсруулах учиртай. Нэгэнт боловсруулсан ЦТҮХ-өө Улс орнууд орон нутаг дахь бодит байдал, сургамж, судалгаа шинжилгээн дээр үндэслэн, оролцооны аргаар байнга нэмж засаж сайжруулдаг байх учиртай.

Эдгээр хөтөлбөрүүд нь цөлжилтөнд нөлөөлж буй хүчийн зүйлсийг тодорхойлох, цөлжилттэй тэмцэх, ган хуурайшилтыг бууруулахад чиглэгдсэн бодит арга хэмжээнүүдийг тодорхойлсон байна. Хөтөлбөрт Засгийн газар, орон нутгийн нөхөрлөл, газар ашиглагчидын үүрэг ролийг нарийвчлан тодорхойлж, ямар нөөц хэрэгтэй байна вэ, ямар нь боломжтой байна вэ гэдгийг нарийвчлан тусгасан байх ёстой.

Конвенциос ЦТҮХ-т /Хүснэгт 1/ тавигдах 7 үндсэн шаардлага болон нэмэлт 5 сайн дурын элементийг /Хүснэгт 2/ гаргасан байдаг. Мөн Конвенци нь үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдийг /Хүснэгт 3/ тодорхойлсон байдаг ба цөлжилтөнд нэрвэгдсэн Талууд өөрсдийн өвөрмөц нөхцөл байдлаас шалтгаалан тэдгээрийн зарим хэсгийг нь авч, өөрсдийн ЦТҮХ-т тусгасан байх учиртай.

Улс орнууд нь Цөлжилттэй тэмцэх Конвенцийг бүсийн ба дэд бүсийн хөтөлбөртэй уялдуулан боловсруулсан “Цөлжилттэй тэмцэх үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр” /ЦТҮХ/-өөрөө дамжуулан хэрэгжүүлэх учиртай. Цөлжилттэй тэмцэх үр ашигтай үйл ажиллагааг орон нутгийн түвшинд авч хэрэгжүүлэх хэрэгтэй ба тэр нь орон нутгийн нөхцөл байдалд нийцэж, дасан зохицсон байх учиртай. Түүнчлэн улс орны үндэсний болон бүсийн стратегийг уялдан, тэдгээр стратеги хөтөлбөрт тэргүүлэх чиглэл болсон үйл ажиллагааг ЦТҮХ-т тусган, ямар нэг давхцал, завсардалгүйгээр, санхүүгийн нөөцийг аль болох бүрэн дүүрэн, үр ашигтайгаар ашиглан хэрэгжүүлэх ёстой юм. ЦТҮХ нь Цөлжилттэй тэмцэх Конвенцийн хамгийн “цөм” нь байна. Цөлжилтөнд нэрвэгдсэн улсууд нь ЦТҮХ-ийг өөрийн улсын стратеги бодлогын “төв элемент” болгон боловсруулж, нийтэлж, хэрэгжүүлэх хэрэгтэй. Амжилттай хэрэгжиж байгаа хөтөлбөр, төлөвлөгөөн дээр үндэслэн ЦТҮХ-өө боловсруулах нь зүйтэй. Түүнчлэн улс орны тогтвортой хөгжлийн бодлогын бүрэлдэхүүн хэсэг, хүчин зүтгэлүүдтэй

ХҮСНЭГТ 2

Сайн дурын элементэл:

- Урьдчилан сэрэмжлүүлэх систем болон байгаль орчны цагаачлагчдад туслах механизмыг бий болгох, бэхжүүлэх
- Орон нутгийн, бүсийн, үндэсний түвшинд гангаас хамгаалах бэлтгэл байдлыг ханган, бэхжүүлэх, гангийн үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах менежментийг бэхжүүлэх
- Хоол тэжээлийн аюулгүй байдлын системийг /үүнд: орон нутаг дахь хүнсний хадгалалт, худалдаалах тоног төхөөрөмж/ бүрдүүлэх, бэхжүүлэх
- Гангийн нөлөөнд нэрвэгдсэн газрын хүн амын амьжиргааны орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн, амьжиргааны боломжит хувилбарыг дэмжсэн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Ургачын болон малын тогтвортой усалгааны системийг хөгжүүлэх

ХҮСНЭГТ 3

Үйл ажиллагааны 8 тэргүүлэх чиглэлд:

- Амьжиргааны боломжит хувилбарыг тодорхойлох, ядуурлыг бууруулахад чиглэгдсэн хөтөлбөрөөр дамжуулан үндэсний эдийн засгийн орчинг сайжруулах болон хоол тэжээлийн аюулгүй байдлыг хангах
- Хүн ам зүйн шилжилт хөдөлгөөн
- Байгалийн нөөцийн тогтвортой менежмент
- Тогтвортой хөдөө аж ахуй, газар тариалангийн практик
- Эрчим хүчний олон янзын эх үүсвэрийн ашиглалт ба хөгжил
- Байгууллагын бүтцийн болон хууль эрх зүйн хүрээ
- Үнэлгээний чадавхийг бэхжүүлэх, системтэйгээр ажиглалт хийх /үүнд: гадаргын усны болон цаг уурын ажиглалт орно/.
- Чадавхийг бүрдүүлэх, боловсрол, олон нийтэд таниулах сургалт, сурталчилгаа

Дээрхи бүгдийг дэд бүсийн болон бүсийн хөтөлбөрт нэвтрүүлэн ашиглана.

Цөлжилтөнд нэрвэгдсэн орнуудын Талууд нь Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн үр ашигт талыг нэмэгдүүлэх, бодит байдалд нийцүүлэх, иж бүрэн болгож боловсруулахын тулд хамтран ажиллаж, харилцан зөвшилцөхөөр санал нэгдсэн байна.


Талууд нь Нэгдсэн Үндэстний систем болон бусад Засгийн газар хоорондын байгууллагууд, Шинжлэх ухааны байгууллагууд, ТББ-уудыг тэдний ЦТҮХ-ийг дэмжин ажиллахад уриалан дуудаж байна. Хөгжингүй орнууд нь шууд болон олон талт байгууллагуудаар дамжуулан хөгжиж буй, цөлжилтөнд нэрвэгдсэн орнуудад тусламж, дэмжлэгийг үзүүлнэ. Африкийн болон бусад буурай хөгжилтэй орнууд нь Конвенцийн Талууд

анхааралдаа авч, нэнэ тэргүүнд тусламж үзүүлэх шаардлагатай улс орнууд болж байна. Конвенци дэмжлэг тусламжийн нарийвчилсан арга хэмжээнүүдийг тодорхойлсон ба үүнийг Хүснэгт 4-т тусгасан байна.

ХҮСНЭГТ 4

ЦТҮХ-т дэмжлэг үзүүлэх арга хэмжээнүүдэд:

- Үйл ажиллагааны хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг тодорхой хэмжээгээр хангах зорилгоор санхүүгийн хамтын ажиллагааг өрнүүлэх, улмаар урт-хугацааны төлөвлөлтийг хийх нөхцөл бий болно.
- Хамтын ажиллагааны механизмыг бий болгож ашиглах нь орон нутгийн түвшинд дэмжлэг үзүүлэх боломжийг бүрдүүлнэ. Энэ нь ТББ-уудаар дамжуулан хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм. Амжилттай хэрэгжсэн “жишээ төсөл”-ийн үйл ажиллагааг ижил төстэй газарт хуулбарлан хэрэгжүүлэх
- Төслийн загвар, санхүүжилтийг гаргахад уян хатан байх, туршилт хийх замаар хэрэгжүүлэх, орон нутгийн нөхөрлөлийн түвшин дэх оролцооны үйл хэрэг бүхий олон удаагийн арга хандлагыг тодорхойлох
- Хамтын ажиллагаа болон тусламж үзүүлэх хөтөлбөрийн үр ашгийг нэмэгдүүлэх захиргаа, санхүүгийн процессыг тодорхойлох



11 Чадавхи бүрдүүлэх

Улс орны удирдан чиглүүлэгч байгууллага нь хүчирхэг бус, ард иргэд нь гадны үзүүлж буй тусламж дэмжлэгийг үр ашгийг мэдэрдэггүй байвал цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр нь төдийлөн үр ашигтай хэрэгжихгүй, цөлжилттэй тэмцэх, гангийн нөлөөг бууруулах үйл хэрэг нь амжилтгүй болно. Тиймээс Конвенци нь цөлжилттэй тэмцэх, гангийн нөлөөг бууруулах чиглэлээр чадавхийг бүрдүүлэх, олон нийтэд таниулах чиглэлд ихээхэн анхаарал тавьж ажиллахыг чухалчилж байна.

Талууд нь байгууллагын чадавхийг бүрдүүлэх, хүмүүсээ сургах, үндэсний болон орон нутгийн түвшинд чадавхийг бэхжүүлэх шаардлагатай гэдэгт санал нэгдэж байна. Тэд мөн хамтын ажиллагааг өрнүүлж, оролцоог хангах замаар Конвенцийг түгээн дэлгэрүүлнэ гэдэгт санал нэгдэж байна.

Цөлжилтөнд нэрвэгдсэн, хөгжиж буй орнууд нь өөрсдийн чадавхи, нөөц боломжоо судалж, Конвенцийн талууд, Засгийн газар хоорондын байгууллагууд болон Төрийн бус байгууллагуудтай хамтрах замаар чадавхиа бэхжүүлнэ хэмээн үзэж байна. Засаг захиргааны байгууллага, хууль эрх зүйн хүрээг сайжруулж, шаардлагатай бол шинээр байгуулах шаардлагатай.

Үндэсний хэмжээний сургалт, судалгааны хүчин чадал, стратеги төлөвлөлт, менежментийг сайжруулах хэрэгтэй ба оролцооны аргыг ашиглаж орон нутгийн салбар байгууллагуудын ажилчдыг сургаж чадавхижуулах шаардлагатай. Орон нутгийн хүмүүст өөрсдөө төлөвлөгөө, хөтөлбөрөө боловсруулж, байгаа нөөцөө удирдан зохицуулдаг болох чадвар, чадавхийг бий болгох нь магадгүй хүн ам, эрх мэдэл, байгаль орчны эрүүл, ухаалаг харилцаа холбоог бий болгоход хамгийн чухал алхам болж болох юм.

Технологийн ололт амжилтыг хүлээн авч, бусад түгээж өгч байх ёстой. Техник технологийг орон нутгийн иргэдэд түгээн дэлгэрүүлэх ажлын суурийг тавьж, хэрэгжүүлж эхлээд байна. Үүний хажуугаар Талууд мэдлэг, мэдээлэл, ноу-хоу, орон нутгийн иргэдийн туршлагыг “доороос-дээш” чиглэсэн аргаар дамжуулан нийтэд түгээн дэлгэрүүлэх, ашиглах явдлыг дэмжиж байна.

Үүний адилаар конвенцийн Талууд түлшний модноос шууд хамааралтай байх явдлыг багасгахын тулд ашиглаж болохуйц технологи, сургалтын боломжит хувилбарыг тодорхойлж, хэрэгжүүлэх, ялангуяа сэргээгдэх эрчим хүчийг дэлгэрүүлж байна. Талууд мөн газар тариалан, мал аж ахуй, байгаль орчинд ээлтэй технологийн уламжлалт аргыг орчин үеийн нөхцөлд уялдуулан хэрэглэхэд санал нэгдэж байна. Улмаар амьжиргааны боломжит хувилбарыг санал болгож, шинэ чадвар, чадавхийг ард иргэдэд олгоход чиглэсэн сургалтуудыг хийж байна.

Хөгжиж буй орнуудын чадавхийг бэхжүүлэхийн тулд Шинжлэх ухаан, технологийн мэдээ мэдээллийг харилцан солилцох, дүн шинжилгээ хийх, цуглуулахад хамтран ажиллах ба улс орнуудын хоол хүнсний үйлдвэрлэл, гангаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ажлыг хариуцсан шийдвэр гаргагчид, менежерүүд, хувь хүмүүсийг сургахад голлон чиглэж ажиллаж байна.

Талууд олон нийтэд таниулах сургалт, сурталчилгаа хийхэд өөр хоорондоо, Засгийн газар хоорондын болон Төрийн Бус Байгууллагуудтай хамтран ажиллахад санал нэгдэж байна.

Тэд дээрх ажилд хувь нэмэр оруулж, хүмүүсийг өөрсдөдөө хэрэгтэй байгаа мэдээ, мэдээллийг нь авахад дэмжлэг үзүүлэх “Холбоо” байгууллахыг дэмжиж байна.

Талууд мөн цөлжилтөнд өртсөн газар нутаг дахь боловсролын хэрэгцээ шаардлагыг үнэлэх, ялангуяа эмэгтэйчүүд, охидуудад зориулсан боловсрол, бичиг үсэг тайлах хөтөлбөрийг өргөжүүлэх, цөлжилт, гангаас сэргийлэх, түүний талаарх мэдээллийг боловсролын системд оруулах зорилгоор “салбар хоорондын оролцооны хөтөлбөр”-ийг хөгжүүлж, бүсийн боловсрол, сургалтын төвүүдийн сүлжээг бэхжүүлэхэд санал нэгдэж байна.

Түүнчлэн Талууд боловсрол, сургалт, сурталчилгааны ажилд олон нийтийг өргөнөөр, байнга оролцуулах явдлыг хангаж байхад санал нэгдэж байна.

12 Шинжлэх ухаан, технологи

Конвенци нь Шинжлэх ухааны судалгаа, шинжилгээг удирдан зохицуулж, технологийг түгээн дэлгэрүүлэх хамтын ажиллагаагаа хангадаг. Шинжлэх ухааны ололт, технологийн хөгжлийг хамгийн их хэрэгцээ шаардлагатай байгаа газарт нутаг, хүн амд түгээн дэлгэрүүлэхэд чиглэдэг ба ингэхдээ уламжлалт мэдлэг, мэдээлэл, чадвар, туршлагын үнэ цэнийг мөн орхигдуулахгүй чухалчилдаг..

Талууд нь “Байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн хувьд үнэ цэнэтэй, нийгэмд хүлээн авч болохуйц технологийг хөгжүүлэх, хүлээн авч ашиглах, шилжүүлэн түгээх үйл ажиллагааг санхүүжүүлэх, удирдан зохион байгуулах” ажлыг хангана. Тэд үйл ажиллагаа явуулж байгаа мэдээлэлд дүн шинжилгээ хийдэг газар, системийг бүрэн ашиглаж, цөлжилтөнд өртсөн улс орнуудын хамтын ажиллагааг хөгжүүлж, хамгийн нийцтэй, тохиромжтой технологийг нэвтрүүлж, дотоодын зах зээлийн нөхцөл, процессыг хялбаршуулах хөшүүрэг буюу өдөөгчийг бий болгох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэдэгт санал нэгдэж байна. Тэд мөн уламжлалт болон орон нутгийн “технологи, мэдлэг, ноу-хоу, туршлага”-ыг түгээн дэлгэрүүлж, ашиглах, урьд өмнөх технологи, мэдлэгийн судалгаа хийж, сайжруулан дэлгэрүүлж, орчин үеийн технологитэй уялдуулан нийцүүлэх замаар өргөнөөр ашиглахыг дэмжиж байна. Улмаар аливаа технологи, мэдлэг, ноу-хоу, туршлагын ашиглалт, худалдаанаас орон нутгийн иргэд шууд ашиг олж байх тэр нөхцлийг хангана хэмээн Конвенцийн Талууд бие биедээ амлалт өгч байна.

Талууд цөлжилт, гангийн үзүүлэх сөрөг нөлөө, шалтгааны талаарх мэдлэг мэдээлэлийг нэмэгдүүлэх зорилгоор хийх аливаа судалгаа шинжилгээний ажилд дэмжлэг үзүүлнэ. Энэ нь орон нутгийн иргэдээс гарсан тусгай хэрэгцээ шаардлагыг шийдвэрлэж, цөлжилтөнд өртсөн газар нутгийн ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэх арга замыг тодорхойлж хэрэгжүүлэхэд илүү дөхөм болно. Мөн цаг үеэ өнгөрөөсөн, уламжлалт мэдлэг мэдээлэл, ноу-хоу, туршлагыг сайжруулж ашигласнаар тэднийг хамгаалах нөхцөл бүрдэнэ гэсэн үг юм. Орон нутгийн ард иргэд тэдний оюун ухаанаар бүтсэн өмч, түүнээс урган гарсан технологийг худалдаа арилжаанд ашигласнаас гарах үр ашгийг шууд хүртэх ёстой.

Конвенцийн Талууд нь цөлжилтөнд өртсөн, хөгжиж буй орнуудын Талуудад, ялангуяа Африкт судалгаа шинжилгээний хүчин чадлыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр амлалт өгч байна. Тэд орон нутгийн иргэдийн үр дүнтэй оролцооны үр дүнд бий болох тогтвортой хөгжлийг бүрдүүлэх сайжруулсан, хүлээн авч болохуйц, ашиглахад дөхөм технологийг хөгжүүлэх, боломжит усны нөөцийг нэмэгдүүлэх, цөлжилт, ядуурал, шилжилт хөдөлгөөний харилцан хамааралд анхаарсан, улс орнуудын газар нутагт тохирсон судалгааны тэргүүлэх чиглэлүүдийг багтаасан хамтарсан судалгаа шинжилгээний ажлыг өрнүүлэхийг Талууд дэмжиж байна.

Талууд мөн “Байгууллагуудын дэлхийн нэгдсэн сүлжээ”-ээр дамжуулан мэдээ, мэдээллийг харилцан солилцох, дүн шинжилгээ хийх, цуглуулах ажлыг удирдан чиглүүлж нэгтгэхэд санал нэгдэж байна. Ингэснээр “газрын доройтолд системтэй ажиглалт хийх” боломж бүрдэх ба цаашилбал урьдчилан сэрэмжлүүлэх дохиог цаг тухайд нь хийж, эрс тэс уур амьсгалын нөхцөлд тодорхой хугацааны төлөвлөлтийг сайн хийдэг болох нөхцөл бий болно. Ингэж орон нутгийн иргэдийн болон тэр бүү хэл шийдвэр гаргагчдын хэрэгцээ, шаардлага бүрэн шийдвэрлэгдэн хангагдах болно хэмээн Талууд үзэж байна.

13 Санхүүжилт

Конвенцийн хувьд мэдээжийн хэрэг санхүүгийн тусламж, дэмжлэг үзүүлэх асуудал нь зөвшилцөлд хүрэхэд хамгийн түвэгтэй хэсэг нь байдаг. Хөгжингүй орнууд нэмэлт санхүүжилт гаргаж өгнө гэж амлалт өгөхдөө дурамжхан байдаг. Гэхдээ Конвенци нь хөгжиж буй орнуудын Талуудыг хандивлагч, өндөр хөгжилтэй орнуудаас шинээр буюу нэмж санхүүгийн нөөц хүлээн авах нь зохистой гэсэн хатуу байр суурийг баримталж байна. Гэхдээ хөгжиж буй орнуудын Талууд нь илүү их хөрөнгө, санхүүжилт авахыг хүсч байвал цөлжилттэй тэмцэх шинэ бодлого боловсруулж, шинэ хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай болно. Тиймээс Конвенци нь хөгжингүй болон хөгжиж буй орнуудын Талуудын байр суурийг харилцан зохицуулахад харилцан зөвшилцөл хийхийг чухалчлан төвлөрч байна. Санхүүжилт байхгүйн улмаас цөлжилттэй тэмцэх үйл ажиллагаа, бодлого төлвөлгөө хэрэгжихгүй, хичээл зүтгэл талаар болно гэдгийг 1977 оны Үйл ажиллагааны төлөвлөлтийн гажуудал, хямралын жишээ харуулж байна. НҮБ-ийн байгаль орчны хөтөлбөр ирэх 20 жилд цөлжилттэй үр дүнтэй тэмцэхэд жилд 10 тэрбумаас 22,4 тэрбум ам доллар зарцуулах хэрэгтэй хэмээн урьдчилсан тооцоо гаргасан байна. Бодит байдалд хөгжиж буй орнуудын цөлжилттэй тэмцэх үйл хэрэгт зарцуулж буй зардал нь 1980-аад оны үед жилд 1 тэрбум ам.доллараас хэтрэхгүй бага байсан байна. Түүнчлэн байгаа нөөцийг бүрэн дүүрэн, үр ашигтай зарцуулахгүй байна гэдэгч үнэн юм.

Санхүүжилтийн нэг систем бий болгож, хөрөнгө санхүү гаргана гэхээс илүүтэйгээр Конвенци нь байгаа бүхий л сувгуудаас санхүүгийн нөөцийн эх үүсвэрийг бий болгохыг зорьж байгаа ба боломжит санхүүжилтийг нэгдсэн, “доороос-дээш” чиглэсэн арга хандлагад нийцүүлэн өсгөх, дахин хуваарилахад анхаарч байна. Хөрөнгө санхүүжилтийг бага хэмжээгээр багсцалж, буцалтгүй тусламж олгох болон зээлийн хэлбэрээр орон нутгийн иргэдэд түгээх явдал нь хөрөнгийг бюрократ тогтолцоотой Засгийн газрын байгууллага, өндөр цалинтай гадаадын зөвлөхөөр дамжуулж олгохоос хавь илүү, хамгийн шилдэг хэлбэр юм. Конвенци нь хөрөнгө оруулалт, тусламжийг цөлжилт, гангийн нөлөөнд бодитой өртсөн газар нутгийн хүн амд олгох нь зүйтэй хэмээн үзэж байна.

Конвенци нь санхүүгийн үндсэн нөөц /шинэ болон нэмэлт санхүүжилт/ хэрэгтэй байна гэдгийг мөн онцолж байна. Хөгжингүй болон хөгжиж байгаа Талууд аль аль нь хангалттай хэмжээний санхүүгийн нөөцийг бий болгоход өрсдийн бүхий л хүчин чадлаа ашиглах болно гэдэгт санал нэгдэж байна.

Цөлжилтөнд нэрвэгдсэн улс орнуудын Талууд: “Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд тэдэнд хангалттай хэмжээний санхүүгийн нөөцийн эх үүсвэрийг бүрдүүлэх шаардлагатай байна” гэдгийг онцолж байна. Нөгөө талаас хөгжингүй орнуудын Талууд нь цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулах нь харин буцалтгүй тусламж болон зээл бүхий санхүүгийн үндсэн нөөцийг бий болгох нөхцөл болно гэсэн байр суурийг баримталж байна. Тэд мөн: “НҮБ-ийн байгаль орчны хөтөлбөр, НҮБХХ, Дэлхийн банкны хамтран хэрэгжүүлдэг, дэлхийн байгаль орчныг хамгаалахад чиглэсэн төсөл хөтөлбөрийг хөгжиж буй орнуудад санхүүжүүлдэг “Даян дэлхийн байгаль орчны сан”-аас шаардлагатай цагт нь хангалттай, төлөвлөсөн, шинэ болон нэмэлт санхүүгийн нөөцийг гаргаж санхүүжүүлж байна” шэдэгт санал нэгдэж байна.

Хөгжингүй орнууд нь технологи, мэдлэг мэдээлэл, ноу-хоу-г түгээн дэлгэрүүлэх ажлыг удирдан хэрэгжүүлнэ гэдэгт санал нэгдэж, мөн шинэ ололт, нээлт, нөөцийг бий болгох тусламжийн сан, ТББ, хувийн салбарын аж ахуйн нэгжүүд зэрэг хөшүүрэг өдөөгчийг гаргахад хөгжиж буй орнуудтай хматран ажиллана гэж үзэж байна. Энд мөн хөгжиж буй орны өрийн дарамтыг багасгах замаар тэдний санхүүг нэмэгдүүлэх өрийн солилцоо орно. Конвенцийн Талууд нь нэнэ тэргүүнд анхааран, тусламж дэмжлэг үзүүлэх орнуудад цөлжилтөнд өртсөн Африкийн орнуудын Талууд хэмээн онцолж, харин бусад бүс нутаг дахь төстэй улс орнуудыг анхааралдаа авч үзнэ хэмээн ч үзэж байна. Улмаар Конвенцийг Африкийн бүсэд хэрэгжүүлэх тухай хавсралтанд Африкийн орнуудын Талуудад ихээхэн

хэмжээний санхүүгийн нөөцийг цаашид үргэлжлүүлэн хуваарилж, мөн нөөцийг улам бүр нэмэгдүүлнэ гэдэгт санал нэгдсэн байна.

Цөлжилтөнд өртсөн хөгжиж буй орнууд болон бүсийн байгууллагууд нь цөлжилттэй тэмцэх үндэсний, дэд бүсийн, бүсийн хөтөлбөрүүдээр дамжуулан харилцан зөвшилцлийн үйл явцыг дэмжин хэрэгжүүлэх болно. Африкт энэхүү зөвшилцлийн баримт бичиг нь цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг санхүүжилэхэд Засгийн газар, хандивлагч, ТББ-ууд ямар үүрэг ролтой байхыг тодорхойлсон “түншлэлийн хэлэлцээр” байна. Энэ түншлэлийн хэлэлцээр нь санхүүжилтийн эх үүсвэрийг гаргах, олсон санхүүжилтийг хэрхэн нэгдсэн зарчмаар өсгөх, хэрхэн зарцуулахыг тодорхойлоход тусалдаг.

Хөгжингүй болон хөгжиж буй орнуудын Талууд нь аль аль нь санхүүжилтийг үр ашигтай зүйд хийх, санхүүжилтийг нэмэгдүүлэх, хуваарилсан нөөцийг арвижуулах, удирдан зохицуулалт хийх, зүй зохистой зарцуулахад анхаарч байна. Тиймээс тэд хуваарилсан санхүүжилтийг үр ашигтай, үр дүнтэй зарцуулах, өөрсдийн амжилт, дутагдалдаа үнэлгээ хийж, учирч буй саад тогторыг зайлуулж, шаардлагатай тохиолдолд цөлжилттэй тэмцэх хөтөлбөрөө Конвенцийн урт хугацааны арга хандлагатай нэгтгэн уялдуулж, дахин шинэчлэхэд анхаарч байна.

Талууд: бүсийн, дэд бүсийн хамтын ажиллагааг хэрхэн бэхжүүлэх вэ? гэдэгт судалгаа хийж, цөлжилтөнд өртсөн, хөгжиж буй орнууд, ялангуяа Африкийн орнуудад үзүүлэх дэмжлэг туслалцаанд тодорхой тэргүүлэх чиглэлийг тогтоож, илүү анхаарал хандуулах хэрэгтэй гэдэгт санал нэгдэж байна.

Конвенци нь тусгай хөрөнгийн “сан”-г байгуулаагүй хэдий ч “Даян дэлхийн механизм”-ийг бий болгосон. Энэ нь цөлийлттэй тэмцэх, гангийн нөлөөг бууруулахад чиглэгдсэн үйл ажиллагааны санхүүжилтын нөөцийн үр ашигт, үр дүнтэй чанарыг нэмэгдүүлэх, цөлжилтөнд өртсөн, хөгжиж буй орнуудад санхүүгийн үндсэн нөөцийг бий болгож, хангахад чиглэгдсэн байна.

Түүнчлэн, Даян дэлхийн механизмийн үйл ажиллагаа нь Үндэсний түвшинд хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, Талууд болон холбогдох байгууллагуудыг боломжит санхүүгийн эх үүсвэр, санхүүжилтийн хэлбэрийн талаарх мэдээллээр хангах зорилготой үйл ажиллагаа явуулдаг. Энд: боломжит хоёр талын болон олон талт хамтын ажиллагааны хөтөлбөрт тоолого, судалгаа хийх, Талуудын гаргасан хүсэлтийн дагуу тэдэнд санхүүгийн тусламжийн эх үүсвэрийн талаар болон мөнгийг хэрхэн өсгөх талаарх шинэлэг, ололттой арга хэлбэрийн талаар зөвлөмж өгөх зэрэг байна.

Конвенцийн Талуудын Бага Хурал нь “Цөлжилтийн үндэсний сан” гэх мэт санхүүгийн механизмыг бий болгож түүгээр дамжуулан орон нутгийн түвшинд санхүүгийн нөөцийг хурдан шуурхай, үр дүнтэй түгээхэд чиглэсэн бодлого боловсруулан гаргахад анхаарч байна.

Хөгжиж буй орнууд нь Үндэсний зохицуулах механизмыг ашиглахад санал нэгдэж байна. Оролцооны арга болон Үндэсний хөгжлийн хөтөлбөртэй нэгтгэсэн энэхүү механизм нь мөнгийг үр ашигтай ашиглах явдлыг хангах ба мөнгийг өсгөн нэмэгдүүлэх, хөтөлбөр хэрэгжүүлэх, тухайн санхүүжилт нь орон нутгийн түвшинд очиж байгаа эсэхэд тавих хяналтын үйл ажиллагаанд Төрийн Бус Байгууллагууд, орон нутгийн иргэд, хувийн секторыг татан оролцуулна. Хандивлагч байгууллага, Талууд нь удирдлага зохицуулалтыг сайжруулж, хөтөлбөрийг уян хатан боловсруулах замаар энэхүү боломжийг бүрдүүлж, холбогдох талуудын идэвхитэй оролцоог нэмэгдүүлж чадна хэмээн Конвенци нь сурталчилж байна.

Нөгөөтэйгүүр, хөгжиж буй орнуудын Талуудын Конвенцийн өмнө хүлээсэн үүрэг хөгжингүй орнуудын Талуудыг Конвенцийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн тохиолдолд, ялангуяа санхүү болон технологийн тусламж үзүүлж, шилжүүлсэн үед л бүрэн биелэгдэх болно хэмээн Конвенци тэмдэглэж байна.

14 Байгууллага, зарчим

Талуудын Бага Хурал нь Конвенцийн эрх барих дээд байгууллага болон байгуулагдсан. ТБХ-ын үүрэг нь Конвенцийг үр дүнтэй хэрэгжүүлэхтэй холбоотой шаардлагтай шийдвэрүүдийг гаргахад оршино. Энэ нь Конвенцийн байгууллагын үүрэг, хэрэгжилтэнд тогтмол хяналт тавьж ажилдаг ба тэдэнд удирдамж өгч, Талуудын хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн талаарх мэдээллийг харилцан солилцох ажлыг удирдан чиглүүлэх зорилгоор тэдний тайланг хүлээн авч, хянаж үздэг.

Конвенци нь мөн тогтмол үйл ажиллагаатай нарийн бичгийн дарга нарын газартай ба Талуудын Анхдугаар Бага хурлаар тус байгууллагын бүтэц, үүргийг тодорхойлон баталсан. Нарийн бичгийн дарга нарын газрын хийдэг хамгийн гол үүрэг нь ТБХ, түүний салбар байгууллагуудын хуралдааныг зохион байгуулж, ТБХ-д хүргүүлсэн тайлангуудыг нэгтгэн мэдээлэх явдал юм. Энэ нь мөн хөгжиж буй орнуудын Талууд, ялангуяа Африкийн орнуудад өгч буй тусламжийг удирдан зохицуулж, Конвенцид шаардлагатай мэдээ, мэдээлэл, харилцаа холбоог нэгтгэн хангаж ажилладаг.

Конвенцийн нарийн бичгийн дарга нарын газар нь өөрийн ажлын тайлангаа ТБХ-д тайлагнадаг ба үндсэн үйл ажиллагаагаа явуулахдаа бусад Конвенциуд, олон улсын байгууллагуудын нарийн бичгийн дарга нарын газартай хамтран хэрэгжүүлдэг.

Конвенцийн Шинжлэх ухаан, технологийн салбар дундын хороо Шинжлэх ухаан, техникийн мэдээлэл, зөвлөгөөг өгдөг ба энэ нь улс орнуудын Засгийн газруудын төлөөлөлөөс бүрдэж, Конвенцийн бүх Талуудад нээлттэй байна. Конвенци нь сүлжээ, байгууллага, агентлагуудад судалгаа хийж, тэдгээрийг хэрхэн сайн холбож ажиллах талаар зөвлөмж гаргаж өгдөг.

ТБХ нь бие даасан шинжээчдийн бүртгэл, нөөцийг бүрдүүлдэг ба тухайлсан асуудлаарх зөвлөмж, мэдээлэл гаргахад “түр зуурын баг” байгуулан ажиллуулдаг.

Конвенцийн бүх Талууд нь Конвенцийг хэрэгжүүлэхтэй холбоотой ямар ажил хийсэн талаарх ажлын тайлангаа ТБХ-д гаргаж өгөх ёстой. Цөлжилтэнд өртсөн улс орнууд Конвенцийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхийн тулд стратеги боловсруулж, түүнийгээ үйл ажиллагааны хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлнэ. ТБХ нь цөлжилтэнд өртсөн орнуудад, ялангуяа Африкийн орнуудын Талуудад үзүүлэх санхүү, техникийн тусламжийг баталдаг.

Хөгжингүй орнуудын Талууд нь хөгжиж буй орнуудын Талууд, тэдний цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх ажилд нь ямар тусламж дэмжлэг үзүүлсэн, санхүүгийн ямар тусламжийг тэдэнд үзүүлсэн талаарх тайлангаа гаргаж өгөх ёстой.


Конвенцийн ямар ч Тал Конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулахаар санал гаргаж болно.

Тэр саналыг Талуудын ээлжит бага хурлаар баталдаг ба ингэхдээ зөвшилцөлд тулгуурлаж, хамгийн сүүлийн тайланд тусгаснаар нийт Талуудын гуравны хоёр буюу олонхийн саналаар батална гэсэн байна. Конвенцид нэмэлт хавсралт оруулахад мөн энэ замаар баталдаг ба гэхдээ тухайн бүсийн хавсралтанд шинээр нэмж зүйл оруулах бол тухайн бүсийн нийт Талуудын гуравны хоёр буюу дийлэнх олонх нь хүлээн зөвшөөрсөн байх ёстой. Тал бүрт нэг саналын эрх байх ба Бүсийн эдийн засгийн интеграцийн байгууллага нь зарим нэг асуудалд санал өгч оролцож болдог.

Аливаа маргаантай асуудлыг шийдвэрлэхэд ямагт зөвшилцлийн замаар, энхийг сахиулах арга зарчмыг баримтална. Талууд Конвенцид нэгдэн орохдоо тэдэнд тулгарсан аливаа маргаантай асуудлыг Арбитрын шүүхээр эсвэл Олон улсын шударга ёсны шүүхийн алинаар нь шийдвэрлүүлж байхыг сонгох ёстой байдаг. Хэрвээ маргалдагч хоёр Тал тухайн асуудалд санал нэгдэхгүй 12 сар болбол тэд цаашид “Эвлэрлийн хороо”-нд хандах хэрэгтэй болно. Аль нэг Тал Конвенцид элссэн нь хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш гурван жилийн туршид дуртай цагтаа Конвенцид мэдэгдэл өгч Конвенциос гарч болно. Уг мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд эсвэл гарах тухай мэдэгдэлд заасан хугацаанд Конвенциос гаргах асуудал шийдэгдэнэ.

Конвенци нь хүчин төгөлдөр болохын тулд доод тал нь 50 улс орнуудын Талуудыг өөртөө нэгтгэсэн байх ёстой ба нэгэнт 50 улс нэгдэн орсон бол түүнд нэгдэн орсон тухай баримт бичгээ Нэгдсэн үндэсний байгууллага хадгалуулахаар өгснөөс хойш 90 дэх хоног дээрээ хүчин төгөлдөр болно.


Зураг4: Хүчин зүтгэл, оролдлогуудыг удирдан зохицуулах, бүх түвшинд харилцан уялдсан урт хугацааны стратегийг бий болгох шаардлагатай байна.



15 Африк

Африкийн
хөрсний
талхагдаал

Конвенци нь Африк тивд тэргүүлэх чиглэлийн анхаарлыг тавьдаг ба бусад 4 эх газруудад Конвенцийг хэрэгжүүлэх тухай хавсралтаас Африкийнхийг тэргүүнд тавьдаг. Африк тивд цөлжилт нь хамгийн ихээр нөлөөлж байна. Энэ бүсийн нийт хуурай газрын гуравны хоёр нь цөл, хуурай газар байдаг ба бүсийн газар тараилангийн талбайн 73 хувь нь хэсэгчилсэн ба нилээд их хэмжээгээр доройтсон байна. Хахир хатуу ган гачиг тогтмол тохиолдож, олон улс орнууд ган болон цөлжилтөнд гүн гүнзгий өртөж байна. Ихэнх цөлжилтөнд өртсөн улс орнууд нь далайд гарцгүй ба харилцаа холбооны хувьд хүндрэлтэй хязгаарлагдмал



улсууд байна. Хамгийн их тулгамдаж зовоож буй асуудал нь ядуурал маш ихээр тархсан, тэдгээрийн дийлэнх нь дэлхийн хамгийн буурай хөгжилтэй орнууд байдаг. Тэдгээр нь байгалийн нөөцөөс шууд хамааралтай амьдардаг ба олон улсын тусламж дэмжлэг маш их хэрэгтэй байна. Тэдний байгууллага, дэд бүтэц маш сул хөгжсөн, өр төлбөр, улс төрийн тогтворгүй байдал, худалдаа арилжааны доройтол, хэлбэлзэл их байдаг. Дээрх шалтгаануудын улмаас Конвенци нь Африки тивийн улс орнуудын Талуудад бүрэн хэмжээгээр тусламж дэмжлэг үзүүлэхийг онцолж байна.

Хөгжингүй орнууд нь Цөлжилтөнд өртсөн Африкийн улс орнуудад нэн тэргүүнд туслах хэрэгтэй хэмээн тэдний цөлжилттэй тэмцэх, гангийн нөлөөг бууруулах үйл хэрэгт үзүүлж буй санхүүгийн тусламжаа цаашид үргэлжлүүлэн үзүүлэх, нөөцийг нэмэгдүүлэхэд анхааран ажиллахад санал нэгдэж байна. Африкийн орнуудын Талууд нь ядуурлыг үндсээр нь устгах “төв стратеги”-ийг боловсруулах амлалт өгөөд байна. Тэд Африк тивд хамгийн нэн тэргүүний шаардлагатай гэж үзсэн газарт хөрөнгө, санхүүг хуваарилахыг зорьж байна. Түүнчлэн төвлөрлийн сааруулах, байгалийн нөөцийг эзэмшүүлэх, орон нутгийн оролцоог хүчтэй дэмжих зэрэг эрс шинэчлэлийг улам бэхжүүлэх, гүнзгийрүүлэхээр амлалт өгч байна.

Эдгээр орнууд нь орон нутгийн иргэд, нөхөрлөлийн оролцоог дээд зэргээр хангах замаар цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулах ёстой ба ЦТҮХ нь тогтвортой хөгжлийн бодлогын “төв буюу нэг хэсэг” нь болох учиртай. Хөтөлбөрийн агуулга дахь өвөрмөц тусгай хэсэг нь Конвенцийн үндсэн эх бичвэрт тусгагдсан байна.

Хөтөлбөрүүд нь цөлжилт, ганг үүсгэж буй хүчин зүйлсийг тодорхойлсон байх учиртай ба өмнө тулгамдсан аюул заналыг даван туулж, орон нутгийн иргэд, нөхөрлөл үүнд эмэгтэйчүүд, тариачид, малчдад илүү их үүрэг хариуцлага өгөх асуудлыг тусгасан байх ёстой.

Энэ нь мөн “ядуурлыг уг үндсээр устгахад чиглэгдсэн эдийн засгийн орчныг сайжруулах арга хэмжээ”-г агуулсан байх ба Конвенци нь ялангуяа хамгийн ядуу бүлгийн орлогыг нэмэгдүүлэх, ажил эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, хөдөөгийн эдийн засгийн урт хугацааны төлвийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн тусгай үйл хэргийг тусгаж оруулсан байна. Тэд: хүн ам, шилжилт хөдөлгөөний бодлогоор дамжуулан газарт үзүүлж буй дарамтыг

бууруулах, ганд тэсвэртэй ургацыг тариалах, хуурай газрын газар тариалангийн системийг нэгтгэх замаар хоол тэжээлийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх ёстой гэж уриалж байна.

Талууд: “хөтөлбөр нь боловсрол олгох, хөгжлийг хангах, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн боломжит олон янзын хувилбарыг үр дүнтэй ашиглах, эмзэг байгалийн нөөцөд үзүүлж буй дарамтыг багасгахад чиглэгдсэн дэвшилтэт технологийг ашиглах замаар байгалийн нөөцийн нэгдмэл, тогтвортой менежмент явуулж, байгалийн нөөцийг хамгаалахыг зорьсон байна” гэдэгт санал нэгдэж байна.

Төвлөрлийг сааруулах, орон нутгийн иргэдэд газрын эзэмшүүлэх нөхцлийг бүрдүүлэхийн тулд байгалийн нөөцийн менежментийн бүтэц зохион байгуулалт, хууль эрх зүйн орчинг зохистой болгох хэрэгтэй ба үүний тулд Засгийн газрын салбар байгууллагуудын үүрэг ролийн нарийвчлан тодорхойлсон арга хэмжээнүүдийг тодорхойлох ёстой.

Эцэст нь хөтөлбөр нь судалгаа шинжилгээ хийхийг хөхүүлэн дэмжих, үндэсний чадавхийг нэмэгдүүлэх замаар цөлжилтийн талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх, гангийн нөлөөг үнэлэх, мониторинг хийхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг агуулсан ба ёстой.

Гэхдээ ган, цөлжилт нь дан ганц улс үндэсний хил заагаар хязгаарлагддаггүй. Тиймээс хавсралтын Талууд нь бүсийн болон дэд бүсийн түвшинд хамтарсан хөтөлбөрийг боловсруулахаар амлалт өгч байна. Дэд бүсийн хөтөлбөр нь хамтын ажиллагааны дараах 9 чиглэлтэй байна:

- Нэн тэргүүнд тавигдаж буй байгалийн нөөцийн тогтвортой менежментийн хөтөлбөр
- Эрчим хүчний эх үүсвэрийн боломжит хувилбарийг хөгжүүлэх хөтөлбөр
- Хөдөө аж ахуйн хортон шавьж, халдварт өвчинг хязгаарлах менежмент
- Чадавхийг бүрдүүлэх, боловсрол, олон нийтэд сурталчлан таниулах
- Шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагаа
- Урьдчилан сэрэмжлүүлэх систем, гангийн нөлөөг бууруулах хамтарсан төлөвлөгөө
- Ялангуяа орон нутгийн иргэдтэй туршлага солилцох арга замыг нээж илрүүлэх, газрын менежментийг сайжруулах, зохистой технологийг ашиглах зорилгоор хүрээлэн буй орчныг чөлөөлөх
- Дэд бүсийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх
- Худалдаа, зах зээл гэх мэт салбарын бодлого боловсруулах

Конвенцийн Африк тивийн улс орнуудын Талууд нь үндэсний, дэд бүсийн, бүсийн цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийг бэлтгэн боловсруулах, харилцан зөвшилцөх, хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах ба энэ үйл явцад бусад Талууд, байгууллагуудыг оролцуулах учиртай. Талууд бүх түвшинд зөвшилцлийн арга зарчмыг хэрэгжүүлнэ гэдэгт санал нэгдэж байна. Энэ зөвшилцлийн процессоо “Форум хэлбэр”-ээр зохион байгуулж болох ба улмаар харилцан зөвшилцөж, “түншлэлийн хэлэлцээр” байгуулж болох юм. Конвенци нь Африкийн бүсийн улс орнуудын Талууд болон бусад зөвшилцлийн бүлгүүдийн зүгээс хөтөлбөрт оруулсан хувь нэмрийг нь тодорхойлж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг хэрхэн гаргаж зохицуулах талаар, тэргүүлэх чиглэл болон хэлэлцээрийн хэрэгжилт, тэдгээрийг хэрхэн үнэлэх шалгуур үзүүлэлт зэргийг тодорхойлдог. Конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газар нь Африкийн улс орнуудын Талуудын хүсэлтийн дагуу энэ зөвшилцлийн үйл явц болох Форумыг чуулан хуралдуулдаг.

Конвенцийн Засгийн газар хоорондын зөвшилцлийн хороо нь Африкт хэрэгжүүлэх нэн тэргүүний үйл ажиллагааны заалтыг баталсан ба энд үндэсний, дэд бүсийн хөтөлбөрийг боловсруулах, санхүүжилт олгогч буюу хандивлагч талуудтай хэрхэн “түншлэлийн хэлэлцээр” байгуулах талаарх алхамуудыг тодорхойлсон байдаг бөгөөд улс орнуудын Талууд Конвенцид нэгдэн орохоос өмнө тэдгээрийг хэрэгжүүлэхээр амлалт өгч, урилсан байна.

16 Бусад бүс нутаг

Конвенцийг хэрэгжүүлэх тусгай 4 бүсийн хавсралт байдаг ба тэдгээр нь Конвенцийг тус бүсүүдэд үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн удирдамж, харилцан тохиролцооны баталгаа болдог. Эдгээр хавсралтуудад Талуудад шинээр заасан ямар нэг үүрэг даалгавар байдаггүй ба бүгд Конвенцийн үндсэн текстээс урган гарсан байдаг. Мөн Конвенцийг хэрэгжүүлэх бусад бүсүүдийн улс орнуудын хувьд ЦТҮХ нь тогтвортой хөгжлийн бодлогын үндсэн нэг хэсэг нь болох тухай заасан байдаг.

Ази

Цөлжилт, гангийн нөлөөнд өртсөн хүн амынхаа тоогоор Ази тив нь хамгийн их өртсөн эх газарт ордог. Конвенцийг Азид хэрэгжүүлэх тухай хавсралт нь тус бүсийн улс орон бүрийн өвөрмөц онцлог, хэрэгцээ шаардлагыг онцолсон байдаг ч, тус бүсийн нийт улс орнуудын Талууд нь цөлжилттэй тэмцэх үндэсний, дэд бүсийн, бүсийн түвшний хөтөлбөртэй байж, нэгдсэн зохицуулалттай, нэгдмэл үйл ажиллагааг биелүүлэх гэсэн нийтлэг уриа тай байхыг заасан байна. Цөлжилттэй тэмцэхтэй холбоотой үйл ажиллагаа нь бусад байгаль орчин, тогтвортой хөгжлийн стратегүүдтэй уялдсан, салшгүй нэг хэсэг нь байх учиртай ба ингэснээр цөлжилтөнд өртсөн орнуудын Талуудын цөлжилттэй тэмцэх хүчин чармайлт хамгийн дээд зэргээр үр ашиг хүртэж, үр дүнд хүрэх болно. Тиймээс орон нутгийн түвшинд хийгдэж буй цөлжилттэй тэмцэх үйл хэрэг нь хөдөөгийн ард түмний ядуурлыг бууруулах хүчин чармайлттай хамт байх учиртай.

Хавсралт нь цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр бол цөлжилтөнд өртсөн орнуудын Талуудын “тогтвортой хөгжлийн үндэсний бодлого”-ын салшгүй нэг хэсэг гэж үздэг.

Тиймээс цөлжилтөнд өртсөн орнуудын Талууд нь цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ёстой ба энэ үйл ажиллагаандаа хоёр талт болон олон талт хамтын ажиллагааны байгууллагуудыг зохих хэмжээгээр татан оролцуулах учиртай. Конвенцийн хавсралт нь улс орнуудын Талууд цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрөө боловсруулахад нь нэгдсэн удирдамжийг өгдөг. Тухайлбал, үндэсний хөтөлбөрийг боловсруулах үүрэг хариуцлага бүхий байгууллагыг томилох, оролцооны аргыг ашиглах, цөлжилтөнд өртсөн газрын судалгаа хийх гэх мэт байна.

Хавсралтанд нь мөн Талууд нь дэд бүсийн болон хамтарсан үйл ажиллагааны хөтөлбөртэй байхаар заасан байдаг. Ингэснээр үндэсний цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн үр ашигт байдал нэмэгдэж, иж бүрэн болох болно гэж үзэж байна. Тус удирдамжийг мөрдөж боловсруулсан Төв Ази, Өмнөд Ази, Хойд Ази болон Баруун Азийн дэд бүсийн цөлжилттэй тэмцэх хөтөлбөрүүд байна.

Латин Америк ба Карибын сав нутаг

Латин Америкийн эх газрын бараг дөрөвний гурав нь их хэмжээгээр цөлжсөн ба Конвенцийг тус тивд хэрэгжүүлэх тухай хавсралтанд: Латин Америкийн өргөн уудам газар нутаг нь цөлжилт, гангийн нөлөөнд өртсөн буюу өргөхөд эмзэг байдалтай байна хэмээн тодорхойлсон байна. Цөлжилтөнд өртсөн газарт ашиглаж буй тогтвортой бус хөгжлийн туршлагын улмаас гарч байгаа ургац тариалалт гэнэт тасрах, ядуурал гуйланчлал зэрэг олон нийгмийн асуудлууд тулгарч байна. Хавсралтанд цөлжилтөнд өртсөн орнуудын Талууд цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрөө боловсруулахад анхаарвал зохих сэдэвчилсэн асуудлуудыг тусгасан байна. Эдгээрт ядуурлыг ул үндсээр нь арилгах, амьжиргааны чанарыг дээшлүүлэх, хоол тэжээлийн аюулгүй байдлыг хангах, тогтвортой хөгжил, байгалийн нөөцийн зохистой болон тогтвортой менежмент, биологийн төрөл зүйлийн хамгаалал ба тогтвортой ашиглалт, хүн ам зүйн асуудлуудад нэн тэргүүнд анхаарвал зохистой гэжээ.

Энд мөн гангийн сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, мэдээлэл, үнэлгээг хийх, бэхжүүлэх, цаашид хэрэгжүүлэх,

урьдчилан сэрэмжлүүлэх систем, боломжит хувилбарыг сонгон хэрэгжүүлэх гэх мэт эрчим хүчний эх үүсвэрийн олон янзын хувилбаруудыг хөгжүүлэх, зохицуулах, үр ашигтай ашиглах, чадавхийг сайжруулах, боловсрол, олон нийтэд сурталчлан таниулах, техник, шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагаа ба санхүүгийн нөөц, механизм зэргийг сайжруулах, Конвенцийн хүлээн зөвшөөрсөн, засаг захиргааны төвлөрлийг сааруулахад чиглэгдсэн удирдлага зохион байгуулалт, хууль эрх зүйн орчинг бэхжүүлэх зэрэг ажлууд орж байна.

Талууд нь дээрх үйл хэргийг удирдан чиглүүлэх үндэсний зохицуулагчийг томилоход санал нэгдсэн. Үндэсний зохицуулагчид нь цаг тухай бүрт удирдлага зохицуулалтын уулзалт хурлыг зохион байгуулж, Азийн хавсралтанд тусгасантай төстэй механизмыг бий болгоно. Цөлжилтөнд өртсөн орнуудын Талууд нь зохистой технологи, ноу-хоу-г түгээн дэлгэрүүлэх, бие даан эсвэл хамтран үйл хэрэг авч хэрэгжүүлнэ гэдэгт санал нэгдэж, уриалсан байна.

Газар дундын тэнгис

Газар дундын тэнгис орчмын хөгжингүй орнууд нь ч, хөгжиж буй орнууд нь нэгэн адил цөлжилтөнд өртөж байна. Европын нийт хуурай газрын бараг гуравны хоёр нь цөлжилтөнд хүчтэй өртсөн байна. Газар дундын тэнгисийн хойд эрэг орчмын хур бороо олон янз буудаг, ган гачиг тохиолддог, ядуу хөрстэй, эгц уруу газар нь цөлжилтөнд хүчтэй өртөж, хөрсний элэгдэлд гүнзгий ороод байна. Мөн энэ бүст гарч байгаа олон удаагийн байгалийн түймэр нь ойг сүйтгэж, хүн амын усны тогтвортой бус ашиглалт даамжирч, уламжлалт газар тариалан уналтанд ороод байна. Хотын хүн амын өсөлт, үйлдвэржилт, аялал жуулчлал, усалгааны систем нь эрэг хавийн газар бүгд төвлөрч, улмаар эрэг хавийн улс орнууд дараагийн зуунд асар том тулгамдсан асуудалтай тулгарч болохыг харуулж байна. Хавсралтанд цөлжилтөнд өртсөн орнуудын Талуудын хүлээх үүргийг тусгасан байдаг ба энд үндэсний, дэд бүсийн, бүсийн түвшний болон хамтарсан үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах шаардлагатай гэж заасан байна. Талууд нь тулгамдсан асуудалд судалгаа хийж, тэдгээрийг даван туулж шийдвэрлэхийн тулд өнгөрсөн болон одоогийн хөтөлбөрт үнэлгээ хийх, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг хариуцлага бүхий байгууллага, эзнийг тодорхойлох, орон нутгийн иргэдийг оролцуулах, техник, санхүүгийн хөтөлбөрийг боловсруулах, урьд өмнө бид юу хийсэн гэдгийг үнэлэх, мониторинг хийх, түүнийг ашиглах зэрэг ажлуудыг үйл хэрэг болгох шаардлагатай гэдэгт санал нэгдэж байна. Энэ бүсийн цөлжилтөнд өртсөн орнуудын Талууд нь Конвенцийн хүрээнд санхүүгийн тусламж авах эрхгүй байна.

Төв ба Зүүн Европ

2000 онд болсон Талуудын 4 дүгээр Бага Хурлаар Конвенцийн хавсралтанд Хавсралт 5-ийг нэмж оруулсан ба Конвенцийг Төв ба Зүүн Европийн бүсэд хэрэгжүүлэх тухай хавсралт 5 нь 2001 онд хүчин төгөлдөр болсон байна. Энэ хавсралт нь Төв ба Зүүн Европын цөлжилт, газрын доройтол, гангийн нөлөөнд өртсөн орнуудын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгдсэн байна.

Төв ба Зүүн Европын хэд хэдэн орнууд нь Европын холбооны гишүүн орнууд байдаг ба тэдгээрийн зарим нь хандивлагч орнууд байдаг. Төв ба Зүүн Европын бүсийн тусгайлан нөхцөл байдлыг Хавсралт 5-д тусгасан байдаг бөгөөд энд эдийн засгийн шилжилт, өөр янз бүрийн экосистемд учирсан гангийн нөлөө, газрын доройтол, хөрсний элэгдлийн улмаас үүсэн хөдөө аж ахуйн хямралын нөхцөл байдал зэрэг бусад дарамт, тулгамдсан асуудлуудыг агуулсан байдаг. Зүй бус усалгааны систем, усны нөөцийн хэт их олборлолт, ашиглалт нь химийн бохирдол, ариун цэврийн шаардлага хангахгүй байх, уст үеийн ачаалал алдагдах зэрэгт хүргэж байна. Бохирдол, олон удаагийн ойн түймэр зэргийн улмаас үүсэх ойгүйжүүлэлт нь мөн нэлээн томоохон тугалмдсан асуудал байсаар байна.

Хавсралт нь цөлжилтөнд өртсөн ТЗЕ-ын орнуудад үндэсний түвшинд цөлжилттэй тэмцэх ажлыг өрнүүлэх “өдөөлт” болж өгдөг. Ялангуяа, газрын доройтол ба цөлжилтийн асуудал нь газрын тогтвортой менежментийн хувьд маш чухал асуудал болж байна гэдгийг тус бүсийн улс орнууд аажим аажмаар ухамсарлан ойлгож, улмаар Талууд цөлжилт, газрын доройтолтой тэмцэх үндэсний хөтөлбөрөө боловсруулаад байна.

17 Цаашид авах арга хэмжээ

2007 оны 9 дүгээр сард Испанийн Мадрид хотноо болсон Талуудын 8 дугаар Бага Хурлаар Конвенцийн нийт 192 улс орнууд “2008-2018 онд Конвенцийн хэрэгжилтийг сайжруулах 10 жилийн стратеги төлөвлөгөө, хамрах хүрээ”-г баталсан.

Энэхүү стратегийн эрхэм зорилго нь ядуурлыг бууруулах, байгаль орчны тогтвортой байдлыг бий болгоход дэмжлэг болохын тулд дэлхийн түншүүдийг цөлжилтөнд өртсөн газар нутгийн цөлжилт, газрын доройтол, гангийн нөлөөг бууруулах, хамгаалахад чиглүүлэх явдал юм. Мөн энэ стратеги нь цөлжилт, газрын доройтолтой тэмцэх даян дэлхийн цар хүрээг тодорхойлох үүрэгтэй. 10 жилийн стратеги нь цөлжилт, газрын доройтлыг хязгаарлан зогсоох, хамгаалах, гангийн нөлөөг бууруулах үндэсний, бүсийн бодлого, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх, хөгжүүлэхэд шинжлэх ухаан, технологийн ололт, амжилт, олон нийтэд сурталчлан таниулах, стандарт тогтоох, санхүүгийн нөөцийг бий болгох замаар дэмжлэг үзүүлэх, улмаар ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулахад чиглэгдсэн болно.

Энэхүү шинэ эрх, үүрэг бүхий стратегийг хэрэгжүүлэхийн тулд урт хугацаанд үр нөлөөгөө үзүүлэх 4 үндсэн стратегийн зорилт нь ирэх 10 жилд Конвенцийн бүх хамтрагч талууд, түншүүдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх болно.

Энд:

1. Цөлжилтөнд өртсөн ард иргэдийн амьжиргааны нөхцлийг сайжруулах
2. Цөлжилтөнд өртсөн экосистемийн нөхцөл байдлыг сайжруулах
3. Конвенцийг үр дүнтэй хэрэгжүүлэх замаар даян дэлхийн үр ашгийг бий болгох
4. Үндэсний болон олон улсын оролцогч талуудын дунд үр дүнтэй хамтын ажиллагааны түншлэлийг байгуулах замаар Конвенцийн хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлэх санхүүгийн нөөцийн эх үүсвэрийг бий болгох

Старегийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд Конвенцийн Талуудаас маш их хүчин зүтгэл шаардах болно. Талууд нь өөрсдийн үндэсний тэргүүлэх чиглэлүүдийн хүрээнд, олон улсын нөхөрлөл, түншлэлийг байгуулах замаар 10 жилийн стратегийг хэрэгжүүлж, үйл хэрэг болгох ёстой. Цөлжилтөнд өртсөн, хөгжиж буй орнуудын Талууд, Конвенцийг бүс нутагт хэрэгжүүлэх тухай хавсралтын бусад цөлжилтөнд өртсөн орнуудын Талууд нь өөрсдийн үйл ажиллагааны хөтөлбөрөө болон бусад холбогдох хэрэгжилтийн үйл ажиллагааг Конвенцийн энэхүү 10 жилийн стратегитэй нэн тэргүүнд уялдуулах учиртай. Энэхүү стратеги нь Конвенцийн зарим нэг түлхүүр тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, өөрийн давуу талаа өөрсөдөө байгаа үндсэн хөрөнгө болгон ашиглаж, шинэ бодлого, санхүүжилтын орчны бүрдүүлсэн нөхцлийг ашиглах онцгой боломжийг нээж өгч байна.